



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.07.09 № 148/68
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт 78 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000245025266

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 46 дугаар тэмдэглэлд:

“17.ХЭЛЭЛЦСЭН нь: Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025-01-06 № 4/23
танай 2024-12-31 -ны № 01/10868 -Т

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН
ТАНАА

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ

1516000010

25.01.2025



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,

Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2025.01.07 № 01/84

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА


Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН



9761003580



**МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны бодлогын баримт бичгийн 4.3.9-д “Давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.” гэж, 7.3.22-т “Гамшгийн аюул, өртөнг, эмзэг байдлыг бууруулах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно” гэж, 8.3.2-т “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд дасан зохицох, эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх, хөдөө аж ахуйд даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, гэнэтийн эрсдэлээс учирч болох эдийн засгийн хохирол, эрсдэлийг бууруулна” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.4.9-д “Байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулна” гэж тус тус заасан.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Сүүлийн жилүүдэд Монгол Улс орныг нийтэд нь хамарсан зудын гамшигт үзэгдэл олонтоо тохиолддог болж байгаа нь нийт малчин айл өрх, мал бүхий иргэдийн нийгмийн баталгааг үгүй хийж, энэ хэмжээгээр улс орны эдийн засагт үүсэх сөрөг нөлөөллийг эрс нэмэгдүүлж байна. Тухайлбал, сүүлийн 70 гаруй жилд манай оронд 13 удаагийн зудын улмаас 45 сая толгой мал хорогдсон бөгөөд 2010 онд нийт малын 22% нь хорогдож, 8.6 мянган малчин өрх малгүй болж, 32.8 мянган малчин өрх нийт малынхаа 50 хувийг алдсан байна. Түүнчлэн зудын гамшгаас үүсэх хохирлын хэмжээ эдийн засгийн дундаж үнэлгээгээр 2016 онд 18 тэрбум төгрөгт, 2024 онд 1 их наяд 357 тэрбум төгрөгт тус тус хүрч байгаа нь зудын гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог улам сайжруулах шаардлагатайг харуулж байна.

өрх нийт малынхаа 50 хувийг алдсан байна. Түүнчлэн зудын гамшгаас үүсэх хохирлын хэмжээ эдийн засгийн дундаж үнэлгээгээр 2016 онд 18 тэрбум төгрөгт, 2024 онд 1 их наяд 357 тэрбум төгрөгт тус тус хүрч байгаа нь зудын гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог улам сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх даатгалын тогтолцоо нь эрсдэл тохиолдсоны дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээс зардал багатай, тогтвортой, үр дүнтэй байдаг нь олон улсад нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд байгалийн гамшиг, их хэмжээний эрсдэлийн эсрэг хэрэглэдэг даатгалын шинэлэг төрөл юм.

Монгол Улсын Их Хурлаас 2014 онд баталсан Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулиар малын индексжүүлсэн даатгалын болон дотоодын давхар даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, индексжүүлсэн даатгалын эрсдэлийг хуваарилах, нөхөн төлбөр олгох, даатгуулагч малчны эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж ирсэн. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш давхардсан тоогоор нийт 267 мянган малчин өрх болон мал бүхий иргэний 59.4 сая толгой малыг индексжүүлсэн даатгалд хамруулж, 65 мянган малчин өрхөд 26.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг, үүнээс 2024 онд 22 мянган малчин өрхөд 16.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгоод байна.

Хэдийгээр малын даатгалын эрх зүйн орчныг шинээр бүрдүүлж индексжүүлсэн даатгалыг амжилттай нэвтрүүлсэн боловч жилд дунджаар нийт малчин өрхийн дөнгөж 11-18 хувь, нийт малын 7-10 хувь тус тус даатгалд хамрагдаж байгаа нь эрх зүйн орчныг шинэчлэн баталж, хэрэгжүүлж байгаа төрийн бодлогын зорилт төдийлөн оновчтой хангагдахгүй байгааг харуулж байна. Энэ хүрээнд Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд доор дурдсан үндэслэлийн хүрээнд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага байна. Үүнд:

1.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Нэгдүгээр босго үзүүлэлт зургаан хувь, хоёрдугаар босго үзүүлэлт 30 хувь байна.” гэж, мөн зүйлийн 7.4.-т “Засгийн газар босго үзүүлэлтийг шинэчлэн тогтоохдоо нэгдүгээр босго үзүүлэлтийг нэг хувиар, хоёрдугаар босго үзүүлэлтийг тав хүртэл хувиар нэмэгдүүлж, эсхүл бууруулж болно.” гэж нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг тус тус хатуу хуульчлан тогтоож өгсөн нь малчдын даатгалд хамрагдах сонирхлыг бууруулж, даатгалын үр шимийг хүртэхэд сөргөөр нөлөөлж байна. Иймээс нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг хуульчлан тогтоохгүйгээр мэргэжлийн актуарчдын тооцоололд үндэслэн тогтмол шинэчлэн Засгийн газраас баталдаг байхаар өөрчлөн найруулах шаардлагатай байна.

Даатгалын нөхөн төлбөрийн босго үзүүлэлтийг хуульд хатуу тогтоон заахгүйгээр баталж мөрдүүлснээр малчдын даатгалд хандах итгэл үнэмшлийг сайжруулж, индексжүүлсэн даатгалын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, улмаар малын индексжүүлсэн даатгалын тогтолцоог урт хугацаанд, тогтвортой өргөжин тэлэх ач холбогдлыг өгөх болно.

2.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлд даатгалын нөхөн төлбөрийг малын хорогдлын дүн мэдээг үндэслэн зудын эрсдэлийн хохирол гарсны дараа буюу дараа оны намар тооцоолж олгохоор заасан байгаа нь зудад өртсөн малчдын гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даван туулах боломжийг бууруулж байна.

Иймээс үргэлжлэн бий болох зудын хүнд нөхцөлийг даван туулах хүрээнд даатгуулагч малчин болон даатгалын компани хооронд байгуулсан тухайн жилийн гэрээний дүнг үндэслэн нөхөн төлбөрийн тодорхой хэмжээг нэг удаа урьдчилсан байдлаар олгодог байх шинэ зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй байна.

3.Малчдын даатгалд хандах итгэл үнэмшлийг сайжруулж, индексжүүлсэн даатгалын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, малчин өрх болон мал бүхий иргэдийг ядууралд өртөхөөс хамгаалах зорилгоор банк санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээнд хамрагдаж буй малчин өрх, мал бүхий иргэдийн малыг индексжүүлсэн даатгалд хамруулах шаардлагыг Малчны тухай хуульд шинээр нэмж тусган боловсруулна.

4. Өнөөдрийн байдлаар Үндэсний давхар даатгалын компани нь малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанаас гадна бусад төрлийн арилжааны даатгалын үйл ажиллагааг эрхэлдэг тул хуульд заасан “малын давхар даатгалын компани” гэснийг “давхар даатгалын компани” болгон өөрчлөх шаардлага тавигдаж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Малын индексжүүлсэн даатгалд малчин өрх болон мал бүхий иргэдийн хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааг улам сайжруулах хүрээнд дараах зохицуулалтуудыг тусгана. Үүнд:

- Даатгалын нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг уян хатан тогтоох зохицуулалтыг тусгана;

- Даатгуулагч даатгалын үр шимийг цаг алдалгүй хүртэх, зудын эрсдэлийг хохирол багатай даван туулах зорилгоор нөхөн төлбөрийг хэсэгчлэн урьдчилан олгодог болох зохицуулалтыг тусгана;

- Давхар даатгалын компанийн үйл ажиллагааны хамрах хүрээг хязгаарласан зохицуулалтыг бууруулах өөрчлөлтийг тусгана;

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан малчид гамшгийн эрсдэлийг хохирол багатай даван туулах, малчид даатгалын үр шимийг хүртэх, даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Зудын гамшгаас сэргийлэх, эдийн засгийн хохирол багатай даван туулах хүрээнд даатгалын нөхөн төлбөрийг хэсэгчлэн урьдчилан олгодог болох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

--oOo--

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.3.9-д “Давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно” гэж, 7.3.22-т “Гамшгийн аюул, өртөнг, эмзэг байдлыг бууруулах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно” гэж, 8.3.2-т “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд дасан зохицох, эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх, хөдөө аж ахуйд даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, гэнэтийн эрсдэлээс учирч болох эдийн засгийн хохирол, эрсдэлийг бууруулна” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.4.9-д “Байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулна” гэж заасан нь уг хуулийн төслийг боловсруулах үндэслэлийг бүрдүүлж байна.

Малчдын амьдралын баталгаа болсон мал сүргийг зуд болон бусад гэнэтийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Монгол Улсын Засгийн газар нь Дэлхийн банктэй хамтран Малын индексжүүлсэн даатгал /МИД/ төслийг анх 2005 оноос 2014 оны хооронд амжилттай хэрэгжүүлсний үр дүнд Улсын Их Хурлаас Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийг 2014 онд баталсан. Тус хуулиар малын индексжүүлсэн даатгалын болон дотоодын давхар даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, индексжүүлсэн даатгалын эрсдэлийг хуваарилах, нөхөн төлбөр олгох, даатгуулагч малчны эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж ирсэн.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөж эхэлснээс хойш нийт 10 жилийн хугацаанд давхардсан тоогоор нийт 267 мянган малчин өрхийн 59.4 сая толгой малыг даатгалд хамруулж, 65 гаруй мянган малчин өрхөд 26.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон хэдий ч тус даатгалд жилд дунджаар нийт малчин өрхийн 11-18 хувь л хамрагдаж, нийт малын 7-10 хувийг л даатгуулж байгаа нь төрөөс авч хэрэгжүүлж буй бодлогын зорилгыг хангахгүй байгаа тул хууль тогтоомжид тодорхой өөрчлөлт, шинэчлэлтийг хийх шаардлагатай байна. Иймд, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараах ерөнхий шинэчлэлүүдийг агуулсан байхаар төлөвлөн боловсрууллаа. Үүнд:

1. Уур амьсгалын өөрчлөлт, зудын гамшигт үзэгдэл нэмэгдэхийн хэрээр нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг хуулиар хатуу тогтоож өгсөн байгааг шинэчилж, мэргэжлийн актуарчдын тооцоололд үндэслэн гурван жил тутам уяан хатан баталж, тогтоодог зохицуулалтыг нэвтрүүлэх;

2.Үргэлжлэн бий болох зудын хүнд нөхцөлийг даван туулах хүрээнд даатгуулагч малчин болон даатгалын компани хооронд байгуулсан тухайн жилийн гэрээний дүнг үндэслэн нөхөн төлбөрийн тодорхой хэмжээг нэг удаа урьдчилсан байдлаар олгох;

3.Малчдын даатгалд хандах итгэл үнэмшлийг сайжруулж, индексжүүлсэн даатгалын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, малчин өрх болон мал бүхий иргэдийг ядууралд өртөхөөс хамгаалах зорилгоор банк санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээнд хамрагдаж буй малчин өрх, мал бүхий иргэдийн малыг индексжүүлсэн даатгалд хамруулах шаардлагыг холбогдох хуульд тусгах зэрэг болно.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд дээрх зохицуулалтуудыг нэмж тусгаснаар малчдын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж тогтвортой байдал, зудын эрсдэлийн нөлөөллийг бууруулахад чухал ач холбогдолтой. Тухайлбал, нөхөн төлбөрийг урьдчилан олгохтой холбоотой зохицуулалтыг тусгаснаар малчдын амьжиргааны эх үүсвэрт дэмжлэг үзүүлэх, нөгөөтээгүүр үргэлжлэн тохиолдож болзошгүй зудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Хуулийн төслийг боловсруулах явцад салбарын мэргэжлийн оролцогчдын хамарсан хэлэлцүүлгийг 2 удаа, олон нийтийн хэлэлцүүлгийг 1 удаа зохион байгуулж, яамд болон бусад холбогдох байгууллагуудын саналыг авч тусгасан. Энэ хүрээнд:

- **“Эрсдэлд тэсвэртэй Монгол Улс”** олон улсын форум, хэлэлцүүлгийг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, Малын индексжүүлсэн даатгал болон гамшгийн эрсдэлийн даатгалын талаар хэлэлцэж, даатгалын салбарын олон улсын болон дотоодын оролцогч байгууллагуудын 100 гаруй төлөөлөлтэй санал солилцсон;
- **“Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг”**-ийг 09 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт 7 даатгалын компани болон Монголын даатгалын холбооны 50 гаруй салбарын мэргэжлийн оролцогч, ХХААХҮЯ, ОБЕГ, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөлтэй санал солилцсон;
- Гамшгийн эрсдэлийн улмаас учирч болзошгүй хохирлыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор 12 дугаар сарын 09-ний өдөр **“Зудын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөжүүлэхэд Малын индексжүүлсэн даатгалын оролцоо”** сэдэвт олон нийтийн хэлэлцүүлэгт 21 аймгийн 287 малчид, аймгуудын Засаг даргын тамгын газрын Хүнс, хөдөө аж ахуйн салбарын асуудал эрхэлсэн төрийн албан хаагчид болон даатгалын компанийн төлөөллүүд оролцож, санал солилцсон болно.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд оруулж буй шинэчлэлтийн хүрээнд олон нийтийн хэлэлцүүлэгт оролцсон 181 малчдаас санал асуулга авахад тэдгээрийн 91.7 хувь нь малын хорогдлын босго үзүүлэлтийг уян хатан тогтоохыг дэмжиж, 93.4 хувь нь малын хорогдлын босго үзүүлэлтийг давах нь тодорхой болсон тохиолдолд нөхөн төлбөрийг гэрээний хугацаанд нэг удаа урьдчилан олгохыг дэмжиж, 97.8 хувь нь цаашид малын индексжүүлсэн даатгалд хамрагдах тухай санал өгсөн. Мөн нийт асуулгад оролцсон малчдын 92.8 хувь нь төрөөс малчдад олгож буй дэмжлэг, урамшууллын тодорхой хэсгийг даатгалын хураамжид төлөхийг зөвшөөрөх талаар санал өгсөн болно.

САНГИЙН ЯАМ

**МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА, ТАЙЛБАР**

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.4, 12.5 дахь хэсгийг нэмсүгэй:

1/12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг:

“12.4.Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын энэ хуулийн 6.1-д заасан хугацаанаас өмнө гаргасан мэдээллийг үндэслэн даатгагч энэ хуулийн 4.1.8-д заасан гэрээний хугацаанд нөхөн төлбөрийг нэг удаа урьдчилан олгож болно.”

Тайлбар: Даатгалын тухай хуулийн 10.1.5-д заасны дагуу Даатгуулагч нь даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой арга хэмжээг авах үүрэгтэй. Иргэний хуулийн 439.5 дахь хэсэгт үүнтэй холбогдон гарсан зардлыг даатгагч хариуцахаар заасан байдаг. Иймд гамшигт үзэгдэл болж байх үед малчдад нөхөн төлбөрийг урьдчилан олгож гамшгийн эрсдэлийг бууруулах нь талуудын эрх ашиг, зорилгод нийцнэ.

2/12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг:

“12.5.Энэ хуулийн 12.4-т заасан нөхөн төлбөрийг энэ хуулийн 26.2-т заасан журмын дагуу олгоно.”

Тайлбар: Хуулийн төслийн 12.4 дэх хэсэгт тусгасан зохицуулалттай холбогдуулан нөхөн төлбөр урьдчилан олгох нөхцөлийг холбогдох журамд тусгана.

2 дугаар зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт:

“4.1.9.“давхар даатгалын компани” гэж энэ хуулийн 18.1-д заасан давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэн явуулах, тусгайлсан чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;”

Тайлбар: Даатгалын эрсдэлийг хуваарилах, Монгол Улсад давхар даатгалын тогтолцоог бүрдүүлэх зорилгын хүрээнд тус хуульд давхар даатгалын компани байгуулах зохицуулалтыг тусгасан ба “Хөдөө аж ахуйн давхар даатгалын хуулийн этгээдийг үүсгэн байгуулах тухай” Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 280 дугаар тогтоолоор байгалийн болзошгүй болон гэнэтийн эрсдэлээс малчид, тариаланчдыг хамгаалах зорилгоор олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, дотоодын даатгалын компаниудыг давхар даатган ажиллах зорилго бүхий “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг байгуулсан. Гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулах, давхар даатгалын зардлыг багасгах, үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 303 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг “Үндэсний давхар даатгал” ХК болгон үйл ажиллагааг нь өргөтгөсөн болно.

2/7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг:

“7.2.Энэ хуулийн 7.1-д заасан босго үзүүлэлтийг энэ хуулийн 18.1-д заасан давхар даатгалын компанийн саналыг харгалзан тогтооно.”

Тайлбар: Аймаг, сумдын газар зүйн байршил, цаг уурын гамшигт үзэгдэлд өртөх магадлал харилцан адилгүй байдаг ба малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг хуулиар хатуу тогтоосон байгаа нь малчдын даатгалд хамрагдах сонирхлыг бууруулж, даатгалын үр шимийг хүртэхэд сөргөөр нөлөөлдөг. Босго үзүүлэлтийг малын хорогдлын сүүлийн 30 жилийн статистикт суурилан тогтоодог. Уг хувь нь актуар /статистик, математик, магадлалын аргачлал/ тооцооллоор 6, 30 хувиас их болон бага байх боломжтой. Мөн уур амьсгалын өөрчлөлт, зудын гамшигт үзэгдэл нэмэгдэхийн хэрээр нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг хуулиар хатуу тогтоож өгсөн байгаа нь даатгалыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болгож, малчин даатгуулагчдын даатгалын хамрагдалтад нөлөөлж байна.

3/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг

“12.2.Даатгагч нөхөн төлбөрийг энэ хуулийн 12.4-т зааснаас бусад тохиолдолд хэсэгчлэн олгохыг хориглоно.”

Тайлбар: Хуулийн төслийн 12.4 дахь хэсэгт тусгасан зохицуулалттай холбоотойгоор тус заалтыг өөрчлөн найруулах шаардлагатай байна.

3 дугаар зүйл.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “03 дугаар сарын 01-ний” гэснийг “04 дүгээр сарын 01-ний” гэж өөрчилсүгэй.

Тайлбар: Давхар даатгалын компани нь санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг дараа жилийн 03 дугаар сарын 01-ний дотор ТУЗ-өөр баталгаажуулна гэж заасан байдаг. Гэвч 03 дугаар сарын 01-нд тайланг батлуулах боломжгүй байдаг тул тус цаглабрыг өөрчлөх шаардлагатай. Жишээлбэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага нь 02 дугаар сарын 10-ны дотор тайлан мэдээллээ харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх зохицуулалттай байдаг. Мөн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтад төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 03 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр зохицуулсан байдаг. Гэтэл Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 24.3-т тухайн жилийн тайлан, аудитын дүгнэлтийг дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор ТУЗ-өөр хэлэлцүүлж, баталгаажуулахаар зохицуулсан нь бодит байдал дээр хэрэгжүүлэх боломжгүй байдаг тул тус хугацааг 04 дүгээр сарын 01 болгон өөрчлөхөөр тусгалаа. Мөн хувьцаа эзэмшигчдийн хурлыг 4 дүгээр сарын 30-ны дотор хуралдуулах зохицуулалттай тул тус хурлаас өмнө ТУЗ-өөр батлуулах боломжтой.

4 дүгээр зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “малын” гэснийг хассугай.

Тайлбар: Даатгалын эрсдэлийг хуваарилах, Монгол Улсад давхар даатгалын тогтолцоог бүрдүүлэх зорилгын хүрээнд тус хуульд давхар даатгалын компани байгуулах зохицуулалтыг тусгасан ба “Хөдөө аж ахуйн давхар даатгалын хуулийн этгээдийг үүсгэн байгуулах тухай” Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 280 дугаар тогтоолоор байгалийн болзошгүй болон гэнэтийн эрсдэлээс малчид, тариаланчдыг хамгаалах зорилгоор олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, дотоодын даатгалын компаниудыг давхар даатган ажиллах зорилго бүхий “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг байгуулсан. Гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулах, давхар даатгалын зардлыг багасгах, үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 303 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг “Үндэсний давхар даатгал” ХК болгон үйл ажиллагааг нь өргөтгөсөн болно.

5 дугаар зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Тайлбар: Хуулийн төслийн 12.4 дэх хэсэгт тусгасан зохицуулалттай холбогдуулан тус заалтыг хүчингүй болгох шаардлагатай.

---o0o---

МАЛЧНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малчны тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.3.5 дахь заалт нэмсүгэй.

“12.3.5.Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан байх.”

Тайлбар: Малчдын даатгалд хандах итгэл үнэмшлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгалд хамруулах хөшүүргийг бий болгох зорилгоор банк санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээнд хамрагдаж буй малчин өрх, мал бүхий иргэдийн малыг индексжүүлсэн даатгалд хамруулах шаардлагыг Малчны тухай хуульд шинээр нэмж тусгана.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Тайлбар: Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дагаж мөрдөхөөр тусгана.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.4, 12.5 дахь хэсгийг нэмсүгэй:

“12.4.Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын энэ хуулийн 6.1-д заасан хугацаанаас өмнө гаргасан мэдээллийг үндэслэн даатгагч энэ хуулийн 4.1.8-д заасан гэрээний хугацаанд нөхөн төлбөрийг нэг удаа урьдчилан олгож болно.”

“12.5.Энэ хуулийн 12.4-т заасан нөхөн төлбөрийг энэ хуулийн 26.2-т заасан журмын дагуу олгоно.”

2 дугаар зүйл.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт:

“4.1.9.“давхар даатгалын компани” гэж энэ хуулийн 18.1-д заасан давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэн явуулах, тусгайлсан чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;”

2/7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг:

“7.2.Энэ хуулийн 7.1-д заасан босго үзүүлэлтийг энэ хуулийн 18.1-д заасан давхар даатгалын компанийн саналыг харгалзан тогтооно.”

3/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

“12.2.Даатгагч нөхөн төлбөрийг энэ хуулийн 12.4-т зааснаас бусад тохиолдолд хэсэгчлэн олгохыг хориглоно.”

3 дугаар зүйл.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “03 дугаар сарын 01-ний” гэснийг “04 дүгээр сарын 01-ний” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “малын” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

МАЛЧНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малчны тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.3.5 дахь заалт нэмсүгэй.

“12.3.5.Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан байх.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

САНГИЙН ЯАМ

**МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2024 он

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Зуд болон бусад гэнэтийн эрсдэлээс малчдын амьдралын баталгаа болсон мал сүргийг эрсдэлээс хамгаалах зорилгоор Монгол Улсын Засгийн газар нь Дэлхийн банктэй хамтран Малын индексжүүлсэн даатгал /цаашид “МИД” гэх/ төслийг анх 2005 оноос 2014 оны хооронд амжилттай хэрэгжүүлсэн. Уг төслийг Монгол Улсын 21 аймагт нийт 10 жилийн турш амжилттай хэрэгжүүлснээр төсөл хэрэгжих хугацаанд нийт давхардсан тоогоор 83.5 мянган малчин өрхийн 13.8 сая толгой малыг даатгалд хамруулж, 17 мянган малчин өрхөд 3.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгоод байна.

Улсын хэмжээнд индексжүүлсэн даатгалын шинэ бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлсний үр дүнд Улсын Их Хурлаас Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулан 2014 онд баталсан. Даатгалын эрсдэлийг хуваарилах, Монгол Улсад давхар даатгалын тогтолцоог бүрдүүлэх зорилгын хүрээнд тус хуульд давхар даатгалын компани байгуулах зохицуулалтыг тусгасан ба Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Хөдөө аж ахуйн давхар даатгалын хуулийн этгээдийг үүсгэн байгуулах тухай” 280 дугаар тогтоолоор байгалийн болзошгүй болон гэнэтийн эрсдэлээс малчид, тариаланчдыг хамгаалах зорилгоор олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, дотоодын даатгалын компаниудыг давхар даатган ажиллах зорилго бүхий “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг байгуулсан. Гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулах, давхар даатгалын зардлыг багасгах, үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 303 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг “Үндэсний давхар даатгал” ХК болгон үйл ажиллагааг нь өргөтгөсөн болно.

Тус хуульд анх даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах зорилгоор даатгагчийн эрсдэл хүлээх түвшнээс давсан эрсдэлийн дээд түвшин дэх давхар даатгалын хураамжийг Засгийн газар хариуцахаар зохицуулж байсан. Шинээр байгуулагдсан компанийг санхүүгийн хувьд тогтворжих хүртэл Засгийн газраас ийнхүү 2016-2021 онуудад нийт 1.4 тэрбум төгрөгийг зарцуулж байсан. Давхар даатгалын компани ашигтай ажиллахын хэрээр даатгагчийн эрсдэл хүлээх түвшнээс давсан эрсдэлийн дээд түвшин дэх давхар даатгалын хураамжийг Давхар даатгалын компанид өөрт нь хариуцуулах зорилгоор 2021 онд Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулж байсан. Мөн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаас 2015 онд баталж байсантай холбогдуулан Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулж, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалтыг тус хуульд тусгаж байсан. Ийнхүү одоогийн мөрдөгдөж буй Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль батлагдсанаас хойш нийтдээ 2 удаа өөрчлөлт орсон байна.

Үндэсний давхар даатгал ХК нь 2015 оноос хойш МИД-ын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж давхардсан тоогоор 267 мянган малчин өрхийн 59.4 сая толгой малыг даатгалд хамруулж, 65 гаруй мянган малчин өрхөд 26.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгоод байна.

Гэсэн хэдий ч тус даатгалд жилд дунджаар нийт малчин өрхийн 11-18 хувь л хамрагддаг ба нийт малын 7-10 хувийг л даатгуулж байгаа нь төрөөс авч

хэрэгжүүлж буй бодлогын зорилгыг хангахгүй байгаа тул хууль тогтоомжид тодорхой өөрчлөлт, шинэчлэлтийг хийх шаардлагатай гэж үзэж байна.

Тухайлбал, аймаг сумдын газар зүйн байршил, цаг уурын гамшигт үзэгдэлд өртөх магадлал харилцан адилгүй байдаг ба малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг хуулиар хатуу тогтоосон байгаа нь малчдын даатгалд хамрагдах сонирхлыг бууруулж, даатгалын үр шимийг хүртэхэд сөргөөр нөлөөлдөг. Зудын эрсдэл их тохиолддог зарим аймагт нийт малчин өрхийн 40 хүртэлх хувь даатгуулдаг бол хангайн бүсийн аймгуудаас 5 хувь нь даатгуулдаг байна. Мөн уур амьсгалын өөрчлөлт, зудын гамшигт үзэгдэл нэмэгдэхийн хэрээр нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг хуулиар хатуу тогтоож өгсөн байгаа нь даатгалыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болгож, малчин даатгуулагчдын даатгалын хамрагдалтад нөлөөлж байна.

Түүнчлэн дотоодын давхар даатгалын компанийн үйл ажиллагаа өргөжихийн хэрээр хуульд заасан давхар даатгалын компанитай холбоотой зохицуулалтыг өргөжүүлэх нь зүйтэй байна.

Дээр дурдсан үндэслэлүүдээс гадна Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 4.3.9-д “Давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.” гэж, 7.3.22-т “Гамшгийн аюул, өртөнг, эмзэг байдлыг бууруулах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно” гэж, 8.3.2-т “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд дасан зохицох, эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх, хөдөө аж ахуйд даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, гэнэтийн эрсдэлээс учирч болох эдийн засгийн хохирол, эрсдэлийг бууруулна” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.4.9-д “Байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулна” гэж заасан нь уг хуулийн төслийг боловсруулах хууль эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж байна.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын² /цаашид Аргачлал гэх/ 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Мал аж ахуй нь улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой байдал, цаашдын хөгжилд чухал үүрэгтэй бөгөөд манай орны нийт газар нутгийн 72.1 хувийг ашиглаж, ДНБ-ийн 10.5 хувийг үйлдвэрлэж, нийт ажиллах хүчний 21.6 хувь нь тус салбарт ажиллаж байна. Хүнсний хангамж, аюулгүй байдлын хүрээнд улсын хэмжээнд чухалд тооцогддог, малчдын амьдралын баталгаа болсон мал сүргийг хамгаалах, байгалийн гамшгийн улмаас үүсэх сөрөг үр дагаврыг бууруулах тогтолцоо бий болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газар нь Дэлхийн банктай хамтран 2005 оноос эхлэн нийт 10 жилийн хугацаанд малын даатгалын

бүтээгдэхүүнийг туршин, судалгаа тооцоолол хийсний үр дүнд Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийг боловсруулан 2014 онд баталсан байдаг.

Зуд, байгалийн гамшигт үзэгдлийн улмаас үүссэн хохирлыг бууруулах, эрсдэлээс сэргийлэх, манай орны цаг агаарын онцлогт тохирсон малын даатгалын бүтээгдэхүүн нэвтрүүлэх зорилгын хүрээнд 10 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн төслийн үр дүнд малын даатгалыг индексжүүлсэн байх нь хамгийн тохиромжтой гэж үзсэн байдаг.

Малыг зудаас хамгаалах даатгалын үйл ажиллагаа нь 1990 оноос хойш үндсэндээ уналтад орж, даатгалын систем жинхэнэ утгаараа хөгжөөгүй, тэр дундаа малын даатгал нь нэг талаас маш өндөр зардал болон эрсдэлтэй учир даатгалын компаниуд даатгал хийх сонирхолгүй, бас хангалттай нөөц хөрөнгө байхгүй, нөгөө талаас малчид хураамж төлөх сонирхолгүй, чадваргүй, нөхөн төлбөр авах итгэл үнэмшил байхгүй байсан гэж үзэж болно.

Засгийн газраас малын даатгалын тогтолцоог бий болгохоор “Малын даатгалын тухай” хуулийн төслийг 1995, 1998 болон 2002 онуудад боловсруулан УИХ-д оруулж байсан ч эдгээр хуулийн төслүүд нь батлагдаагүй бөгөөд энэ нь тухайн хууль хэрэгжих магадлал багатай, даатгалын компани болон малчид тухайн даатгалд хамрагдах боломжгүй, зудын улмаас үүсэх хохирлыг барагдуулах санхүүгийн эх үүсвэр тодорхой бус зэрэг шалтгаанаар буцаагдаж байсан. Засгийн газраас 2005 оноос эхлэн малыг даатгалын орчинг судалж индекс суурилсан буюу малчны хотонд гарсан хорогдолд бус сумын төрөл мал тус бүрийн хорогдолд үндэслэн нөхөн төлбөр олгох даатгалын үйл ажиллагааг оролцогч аль аль талаасаа хэрэгжихэд хамгийн дөхөмтэй гэж үзэж, Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр малын индексжүүлсэн даатгал төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Дээрх төслийг хэрэгжүүлэх хугацаанд даатгалын компаниуд уг даатгалын үйл ажиллагааг эрхлэх боломжтой, малчид хамрагдах сонирхолтой, зах зээлийн зарчмаар цаашид үйл ажиллагаа нь үргэлжлэх боломжтой болох нь батлагдсан.

Индексжүүлсэн даатгал нь байгалийн гамшиг, их хэмжээний эрсдэлийн эсрэг хэрэглэдэг даатгалын шинэлэг төрөл бөгөөд олон улсад, ялангуяа газар тариалангийн даатгалд индексжүүлсэн даатгалыг нэвтрүүлэн даатгалын үйл ажиллагааны зардлыг бууруулан даатгуулагчид илүү хүртээмжтэй бүтээгдэхүүн санал болгодог. Үүний адил манай орны тархаа бутархай оршин суудаг малчдын хотонд гарсан хорогдлыг баталгаажуулж хохирол үнэлгээг тооцох зардлыг бууруулж, хүртээмжтэй хямд өртгөөр даатгуулах боломжийг олгосон бүтээгдэхүүн юм.

МИД нь гамшигт үзэгдлийн дараа даатгалд хамрагдсан малчдад зохих хэмжээний даатгалын нөхөн олговрыг олгож хохирлыг нөхөх, бэлэн мөнгө, мал олгож малчдыг бэлэнчлэх сэтгэлгээнд сургахаас зайлсхийх, даатгалын салбарын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, улмаар даатгалын компаниуд энэхүү өвөрмөц аргачлалаар малыг даатгаж олон улсын жишгийг даган зах зээлийн зарчмаар цаашид хөгжих боломжийг нэмэгдүүлэх, зуд болон байгалийн гамшгийн үед Засгийн газрын үүрэх ачааг хөнгөвчлөх, гамшгийн хохирлыг дан ганц төрөөс хариуцах биш тодорхой хэсгийг хувийн хэвшил, олон улсын байгууллага /давхар даатгал/-ын хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх тогтолцоог бий болгож, төр хувийн хэвшлийн түншлэлийг нэвтрүүлсэн тогтолцоо юм. Малын индексжүүлсэн

даатгалын тухай хууль батлагдан мөрдөгдөж эхэлснээс хойш нийт 10 жилийн турш давхардсан тоогоор нийт 267 мянган малчин өрхийн 59.4 сая толгой малыг даатгалд хамруулж, 65 гаруй мянган малчин өрхөд 26.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон хэдий ч тус даатгалд жилд дунджаар нийт малчин өрхийн 11-18 хувь л хамрагдаж, нийт малын 7-10 хувийг л даатгуулж байгаа нь төрөөс авч хэрэгжүүлж буй бодлогын зорилгыг хангахгүй байна.

Хүснэгт 1. МИД-д хамрагдсан малчин өрхийн эзлэх хувь

Аймаг	2020	2021	2022	2023	2024
Архангай	9.1%	10.9%	13%	18.9%	16.1%
Баян-Өлгий	8.4%	9.5%	10%	13.6%	8.9%
Баянхонгор	28.6%	24.8%	20%	30.8%	20.8%
Булган	13.9%	17.3%	15%	22.8%	17.5%
Говь-Алтай	22.8%	26.8%	29%	41.2%	25.3%
Дорноговь	19.1%	24.2%	20%	33.3%	11.3%
Дорнод	14.3%	12.8%	20%	33.1%	17.6%
Дундговь	15.0%	26.2%	18%	21.6%	10.0%
Завхан	14.0%	12.1%	13%	22.1%	14.0%
Өвөрхангай	4.1%	7.7%	6%	6.8%	5.2%
Өмнөговь	8.8%	13.4%	9%	16.3%	3.3%
Сүхбаатар	11.5%	16.7%	19.3%	26.6%	8.8%
Сэлэнгэ	4.5%	9.9%	11%	12.1%	6.2%
Төв	7.2%	12.2%	12%	13.1%	12.1%
Увс	16.6%	15.8%	25%	23.2%	12.6%
Ховд	12.3%	16.6%	39%	10.5%	6.0%
Хөвсгөл	7.7%	9.0%	25%	12.0%	5.6%
Хэнтий	11.2%	12.4%	5%	16.2%	9.2%
Орхон	4.8%	3.7%	5%	5.1%	3.1%
Дархан-Уул	4.7%	5.3%	5%	7.9%	4.2%
Говьсүмбэр	20.3%	33.8%	38%	49.4%	27.5%
Улаанбаатар	0.5%	1.1%	1%	2.6%	2.2%
Улсын дундаж	15.8%	18.4%	14.4%	18.9%	11.3%

Одоогоор арилжааны 7 даатгалын компани, орон нутагт хамгийн их салбар нэгжтэй 2 банкаар дамжуулан МИД-ыг борлуулж жилд дунджаар 30 мянган малчны 7 сая малыг даатгадаг. Даатгалын хамрагдалт аймаг орон нутгаар харилцан адилгүй байдаг ба малын хорогдол бага гардаг хангайн бүсэд малчдын 5-10 хувь даатгуулдаг бол эрсдэл ихтэй аймгуудад 40 хүртэлх хувь нь даатгуулдаг байна.

Малчид даатгалд хамрагдахдаа даатгалын компанийн орон нутаг дах салбарын төлөөлөгчид болон зуучлагч банкуудын салбарт хандаж даатгуулдаг. Нийт борлуулалтын 80 орчим хувийг банкны зуучлалаар борлуулж байна. Банкууд малчдад олгох зээлийн багцын тодорхой хэсэгт МИД-ын бүтээгдэхүүнийг уясан байдаг бөгөөд малчид малаа барьцаалан зээл авахдаа барьцаа хөрөнгөө МИД-д даатгуулдаг бөгөөд зээлийн хүүг сарын 0.2 хувиар бууруулан олгодог. Банкаар дамжуулан даатгахад нэг талаараа малчдын даатгалд хамрагдах тоог

нэмэгдүүлдэг боловч нөгөө талд даатгалын үндсэн ойлголтыг дутмаг авч, буруу ойлголт үүсэх шалтгааны нэг болдог.

Малчид малаа даатгуулахдаа өөрийн малыг хэдэн төгрөгөөр үнэлэн даатгуулах нь нээлттэй байдаг бөгөөд өөрсдийн байгаа бэлэн мөнгөндөө тааруулан ихэвчлэн зах зээлийн үнэлгээний 10-аас 15 хувиар үнэлэн даатгуулдаг нь эргээд төдий хэмжээгээр бага нөхөн төлбөр авах шалтгаан болдог байна.

МИД-ын 2024 оны борлуулалтын статистикийг харвал даатгалын төлөөлөгчөөр дамжуулан даатгуулсан малчдын дундаж хураамж 222 мянган төгрөг бол банкаар дамжуулан даатгуулсан малчдын дундаж хураамж 40 хувиар бага буюу 158 мянган төгрөг байна.

МИД-ын хэрэгжилтийн хугацаанд хамгийн өндөр буюу 16.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгож буй 2023 онд даатгуулсан малчдын хувьд төлөөлөгчөөр дамжуулан даатгуулсан малчдын дундаж хураамж 200 мянга, түүнээс авсан дундаж нөхөн төлбөр 592 мянган төгрөг байгаа бол банкны зуучлалаар даатгуулсан малчдын дундаж хураамж 130 мянга бол дундаж нөхөн төлбөр 454 мянган төгрөг байна.

Ган зудын давтамж нь малчин өрхийн амьжиргаа, тогтвортой байдал, орлогын эх үүсвэрт сөргөөр нөлөөлж, ядуурлыг нэмэгдүүлдэг тул орон нутгаас нийслэлд шилжин суурьших иргэдийн тоо нэмэгдэж жилд дунджаар 24 мянгад хүрдэг байна.

Иймд 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө ахуйн байнгын хорооны 10 дугаар тогтоолоор МИД-ын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, МИД-д оролцогч талууд болох малчид, даатгалын компани, даатгалын зуучлагч, төрийн байгууллагын төлөөлөл болох аймгийн Засаг даргын тамгын газруудаас асуулга судалгаа авсан. Судалгаанд оролцогчдоос МИД-д хамрагдалтын түвшин бага байгаагийн үндсэн шалтгаан нь даатгалын нөхөн төлбөр олгох босго үзүүлэлт болон хураамжийн хувь тус тус өндөр байдаг тул малчдын дийлэнх нь даатгуулах сонирхолгүй үүний улмаас МИД-ын талаарх ойлголт дутмаг байдаг гэж хариулсан байна.

МИД-ын босго үзүүлэлт

МИД-ын тухай хуулийн 7 дугаар зүйлд даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилж нөхөн төлбөр олгох зорилгоор босго үзүүлэлтийг томъёолсон. Хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Нэгдүгээр босго үзүүлэлт зургаан хувь, хоёрдугаар босго үзүүлэлт 30 хувь байна.”, 7.3-т “Засгийн газар доор дурдсан нөхцөлийг харгалзан гурван жил тутам босго үзүүлэлтийг шинэчлэн тогтооно”, 7.4-т “Засгийн газар босго үзүүлэлтийг шинэчлэн тогтоохдоо нэгдүгээр босго үзүүлэлтийг нэг хувиар, хоёрдугаар босго үзүүлэлтийг тав хүртэл хувиар нэмэгдүүлж, эсхүл бууруулж болно.” гэж тус тус заасан.

МИД-ын босго үзүүлэлтийн судалгааг сүүлийн 48 жилийн мал тооллого болон малын хорогдлын мэдээнд үндэслэн хийхэд зарим аймагт нэгдүгээр босго үзүүлэлт 4 хувь болж буурах, зарим аймагт 7 хувь болж өсөх, хоёрдугаар босго

үзүүлэлт зарим аймагт 17 хувь болж буурах, зарим аймагт 48 хувь болж өсөхөөр байна.

Иймд малчдын өмнө тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэхдээ босго үзүүлэлтийг хуульд тусгайлан заахгүйгээр актуар тооцоололд үндэслэн гамшгийн эрсдэлийн нөхцөл байдалтай уялдуулах нь малчдын хамрагдалтыг нэмэгдүүлж, даатгалын үр шимийг хүртэх, малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтэд нөлөөлөх чухал ач холбогдолтой байна.

МИД-ын нөхөн төлбөрийг урьдчилж олгох

МИД-ын нөхөн төлбөр нь Үндэсний статистикийн хорооноос хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааг зохион байгуулж, малын хорогдлын дүн мэдээ гарсны дараа малчдад олгох нөхөн төлбөрийг тооцоолж, дараа оны 10 сард нөхөн төлбөрийг олгодог. Энэхүү хугацаа нь зудын эрсдэл болж дууссаны дараа намар нөхөн төлбөр олгогдож байгаа нь зудад өртсөн малчид гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөн тэсвэрлэх боломжийг бууруулж байна. Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хийсэн судалгаагаар¹ гамшгийн үед эрт сэрэмжлүүлэх зорилгоор урьдчилж олгосон 1 ам.доллар нь 7 ам.доллар болон өсөж үр ашгаа өгдөг гэсэн тооцоолол гарсан байна.

Бусад улс орнуудад гамшиг болсон тохиолдолд нэн даруй нөхөн төлбөрийг олгох туршлага байдаг бөгөөд ингэснээр ирээдүйд гарах их хэмжээний зардлыг бууруулан гамшгийг даван туулж, цаашлаад дахин даатгалд хамрагдах хандлага нь өсдөг байна. Жишээлбэл, Казакстан Улсын газар тариалангийн индексэд суурилсан даатгалд хэрэв гамшигт үзэгдэл босго үзүүлэлтийг давсан тохиолдолд нөхөн төлбөрийг 20 хоногт багтаан олгодог бөгөөд дараа сар нь дахин босго үзүүлэлтээс давсан тохиолдолд нөхөн төлбөрийг дахин тооцож олгодог байна.²

Мөн 2024 онд болсон зудын эрсдэлд хамгийн их өртсөн, хамгийн их мал хорогдсон Сүхбаатар аймгийн сар бүрийн хорогдлын мэдээг хагас жилийн мал тооллогын мэдээтэй харьцуулахад 2024 оны 2 дугаар сард нийт хорогдсон малын 50-70 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл 2 дугаар сард хамгийн их мал хорогдсон байна.

Гамшигт үзэгдэл болж байх үед эрсдэлийг бууруулах зорилгоор МИД-ын нөхөн төлбөрийн тодорхой хувийг малчдад урьдчилж олгох, ингэхдээ Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын сар бүрийн мэдээнд үндэслэн босго үзүүлэлтийг 50 хувиас дээш давах нь тодорхой болсон тохиолдолд нөхөн төлбөрөөс урьдчилан олгож, хагас жилийн түүвэр судалгааны дүн мэдээ эцэслэн гарсны дараа нөхөн төлбөрийг эцэслэх байдлаар зохицуулах боломжтой. Гамшгийн эрсдэлийг хохирол багатай даван туулах, малчид даатгалын үр шимийг хүртэх, даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэхэд эрх зүйн орчныг сайжруулах зайлшгүй шаардлага байна.

¹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын 2018 онд хийсэн судалгаа - Эрт сэрэмжлүүлгийн нөлөөлөл тайлан

²Казакстан Улсын газар тариалангийн индексжүүлсэн даатгалын статистик мэдээлэл
Statistics by types of insurance products - 2024 year

Иймд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, асуудлыг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Дээр дурдсан нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд дараах асуудлууд голлож байна. Үүнд:

МИД-ын нөхөн төлбөр олгох босго үзүүлэлт зарим аймагт өндөр, зарим аймагт бага байгааг өөрчлөх.

Зуд турхан, байгалийн гамшиг болсон үед малчдад хүрэх даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс малчин өрхийн малын тоо, амьжиргааны түвшнээс хамааран даатгалын доод үнэлгээ болон хураамжийг тогтоох.

Бүх шатны засаг дарга, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтнүүдийн оролцоог нэмэгдүүлэх.

Хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.

Зудын гамшигт үзэгдлийн эрсдэлийг бууруулах зорилгоор даатгалын үр шимийг нэмэгдүүлэх.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
Даатгагч	Даатгагчдын хариуцлагыг актуар тооцоололд үндэслэж эрсдэлийн түвшиг тооцоолох учир даатгагчийн эрх ашиг хангагдана.
Даатгуулагч	Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд даатгуулагчид даатгалын бүтээгдэхүүний талаар анхан шатны эрх үүргийг агуулсан мэдээллийг ойлгомжтой гаргаж өгөх, сум орон нутгийн мэргэжилтнүүдийн оролцоог нэмэгдүүлэх.
Давхар даатгагч	Дотоодын давхар даатгалын тогтолцоог хуулиар дэмжсэнээр дотоодын давхар даатгагчийн чадавх нэмэгдэх, даатгалын зах зээл өргөжин тэлэх болно.
Бүх шатны засаг дарга, орон нутгийн хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн	Малчдад малын индексжүүлсэн даатгалын ач холбогдлыг сурталчилан таниулах, мөн зудын гамшиг болсон үед эрсдэлийг бууруулах ажлыг хийж хэрэгжүүлэхэд мэдээлэл өгч ажиллах.

1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох:

Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль нь 2014 онд батлагдсанаар зуд турхан, бусад том малын зүй бус хорогдлын улмаас мал хорогдож малчдад учрах хохирлыг бууруулах, эрсдэлийн түвшинг хуваарилан хариуцах үйл ажиллагаа илүү боловсронгуй болсон.

Тус хуульд даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийн түвшинг хуваарилах зорилготой босго үзүүлэлтийг хатуу зааж өгснөөр даатгалын салбарын үндсэн, мэргэжлийн тооцоолол болох актуар тооцоололд үндэслэн өөрчлөх, мөн малчдын малын индексжүүлсэн даатгалд хамрагдах байдлыг нэмэгдүүлэх зэрэгт сөрөг нөлөө үзүүлэх болсон.

Малын индексжүүлсэн даатгалыг зудын гамшигт үзэгдэлд сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, даатгалын үр шимийг цаг тухайд нь хүртэх зорилгоор ашиглах боломжтой байгаа ба тус зохицуулалтыг хуульд нэмэлт, өөрчлөлт хийх замаар шийдвэрлэх боломжтой байна.

Даатгалын ач холбогдлын талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл хангалттай бус, даатгалын компаниудад итгэх иргэдийн итгэл дутмаг, даатгалд хамрагдсан хэдий ч түүний ач холбогдлыг сайтар ойлгоогүй, мэдээлэл дутуу байх зэрэг сөрөг үзэгдлүүд малчдын дунд түгээмэл байгаа нь мөн асуудал үүссэн шалтгааны нэг нөхцөл болж байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн зохицуулалт нь малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, төрөөс тавих хяналт, даатгалын эрсдэлийг хуваарилах, нөхөн төлбөр төлөх, малын давхар даатгал, даатгагч болон даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн боловч өнөөгийн байдлаар нийт 11-18 хувь л хамрагддаг ба нийт малын 7-10 хувийг л даатгуулж байгаа нь төрөөс авч хэрэгжүүлж буй бодлогын зорилгыг хангахгүй байна.

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойллоо.

Ерөнхий зорилт: Даатгуулагч малчдад хүрэх хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгалын эрсдэлийн хуваарилалтыг сайжруулах, даатгагч, давхар даатгагчдын хамтын ажиллагааг дэмжих, даатгалын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг сайжруулахад.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН ХАРЬЦУУЛАЛТ

Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, аргачлалын 5-д заасны дагуу судалж үзлээ.

3.1. Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй үргэлжлүүлснээр хамрагдалтын цар хүрээ, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сайжруулах нөхцөл бүрдэхгүй байх нөхцөл үүсэх бөгөөд асуудлыг шийдвэрлэхэд үр нөлөө үзүүлэхгүй.

3.2. Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга, сурталчилгааны ажил өрнүүлэх хувилбар.

Асуудлыг шийдвэрлэхийн тулд одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийг олон нийтэд сурталчлан таниулах ажил өрнүүлэх нь зорилгыг хангах хангалттай арга зам биш юм. Энэхүү хувилбар нь үйл ажиллагааг бүрэн зохицуулах, хяналт, хариуцлагыг тодорхой болгох боломжийг бүрдүүлэхгүй бөгөөд үүнд хуулийг олон нийтэд сурталчлан таниулахад тодорхой хэмжээний зардал, хөрөнгийг шаардах хэдий ч үүсээд буй нөхцөл байдлын шалтгааныг арилгаж, үр дагаврыг бууруулах боломжгүй юм.

3.3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулах хувилбар.

Даатгагч, даатгуулагч, болон бусад оролцогч талуудын хамтын оролцоог дэмжсэн, зудын гамшигт үзэгдлийн эрсдэлийг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх, эрх зүйн таатай орчныг бий болгоход өнөөгийн эрх зүйн орчин хангалтгүй байна. Иймд зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан дан ганц төрөөс зохицуулах хувилбар нь үр нөлөөгүй бөгөөд энэхүү хувилбар нь зардал, хөрөнгийг хэмнэх боломжтой ч тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж чадахгүй буюу тулгарч байгаа бэрхшээлийг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй гэж дүгнэж байна.

3.4. Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбар:

Энэхүү хувилбарыг ашиглан төрөөс интервенц хийх нь зардал хөрөнгө зарцуулах сөрөг талтайгаас гадна асуудлын шалтгааныг арилган зорьж буй үр дүнд хүрэхгүй бөгөөд зудын гамшигт үр дагаврыг бууруулахгүй. Хуулийн зохицуулалттай холбоотой асуудал учир энэхүү хувилбарыг хэрэгжүүлснээр зорьж буй үр дүнд хүрэх боломжгүй буюу асуудлын шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулахгүй гэж үзлээ.

3.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх хувилбар:

Одоогийн дагаж мөрдөж буй Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулиар тодорхойлсон чиг үүрэг нь төрийн байгууллагын чиг үүрэгт тусгайлан харьяалуулсан зохицуулалт, хяналтын тогтолцоонд багтдаг бөгөөд төрийн бус байгууллага болох мэргэжлийн холбооны үйл ажиллагаагаар дамжуулан асуудлыг шийдвэрлэх нь боломжгүй юм.

3.6. Захиргааны шийдвэр гаргах хувилбар:

Малын Индексжүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр ган зудын үзэгдэл давтамжтайгаар тохиолдож буй нөхцөлд гэнэтийн эрсдэлээс учирч болох эдийн засгийн хохирол, эрсдэлийг бууруулах төрөөс хэрэгжүүлж буй бодлогын зорилгыг хангах боломжгүй юм. Иймээс давхар даатгалын компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрийн давхар даатгалыг гүйцэтгэх замаар өргөжүүлэх зохицуулалтыг хууль зүйн хүрээнд баталгаажуулах нь үндэсний давхар даатгалын тогтолцооны цаашдын хөгжилд чухал үүрэгтэй юм. Даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихад төрийн байгууллагын хувьд зөвхөн хуулиар тусгайлан эрх олгосон тохиолдолд зөвшөөрөгддөг тул Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан захиргааны шийдвэр гаргах замаар зохицуулах боломжгүй гэж дүгнэлээ.

3.7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар.

Малын индексжүүлсэн даатгалын өнгөрсөн хугацааны хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдалд хийсэн судалгаа, дүн шинжилгээний үр дүнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилтуудыг хангахад зөвхөн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой тул хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг хамгийн оновчтой, үр дүнтэй хувилбар гэж дүгнэж байна.

3.8. Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудын харьцуулалт.

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу хуулийн төсөл боловсруулах зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

№	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа шийдвэрлэх асуудал, бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Ухуулга, сурталчилгаатай холбоотой зардал гарах ба энэ нь олон нийтийн даатгалын талаарх мэдлэгийг зарим талаар нэмэгдүүлэх үр нөлөөг авчирч болох ч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж	Тодорхой үр дүнд хүрэхгүй.

			чадахгүй .	
3	Захиргааны шийдвэр гаргах	Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг баталж тодорхой асуудлуудыг шийдвэрлэж болох хэдий ч зарим нэг зорилгыг хэрэгжүүлэх үүднээс хуульд нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, зорилгод тусгагдсан үр дүнд хүрэх боломжгүй.	Шаардлагатай үр дүнд хүрэхгүй.
4	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанд тулгамдаад байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Энэ нь хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Зорилгод хүрэх байдал, эерэг болон сөрөг талын зардал, үр өгөөжийг хувилбар тус бүрээр харьцуулан үзэж, “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар нь асуудлыг бүрэн шийдвэрлэх үр дүнтэй гарц гэж дүгнэлээ.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Хууль, тогтоомж боловсруулах аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө.

Хүний эрх, эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй Сөрөг нөлөө байхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй Сөрөг нөлөө байхгүй
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй Сөрөг нөлөө байхгүй
	1.2.Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй Сөрөг нөлөө байхгүй

	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө.

Даатгалын салбарын эдийн засагт үзүүлэх үр нөлөө дунд болон урт хугацаанд сайжрах бөгөөд иргэдийн хувьд даатгуулах сонирхол нэмэгдсэнээр малчид, аж ахуйн нэгжийн санхүүгийн баталгаа сайжирна.

Үзүүлэх үр	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
------------	------------------	---------	---------

нөлөө				
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
		Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Гадаадын даатгагч нь тодорхой төрлийн даатгалын төрлөөс бусад даатгалын үйл ажиллагааг Монгол Улсад байрлах төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаа явуулах зохицуулалтыг тусгана.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Дотоодод төлөөлөгчийн газраа байгуулан нөөц бүрдүүлснээр гадаад улсын даатгагч дампуурснаас үүсэх төлбөрийн чадвартай холбоотой эрсдэл буурна.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Даатгалын эрсдэлийг бууруулах үед даатгуулагчид очих хүртээмжийг нэмэгдүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Даатгалын үйл ажиллагаа зохистой түвшинд хүртэл хөгжсөнөөр хувь хүнд тулгарах гэнэтийн санхүүгийн хүндрэлээс сэргийлэх боломж бүрдэнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

	үзүүлэх эсэх			
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Даатгалын үйл ажиллагаа зохистой төвшинд хүртэл хөгжсөнөөр зах зээлийн тогтвортой хөгжилд томоохон түлхэц болно.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө.

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах үйл ажиллагааг урьдчилан олгосноор даатгалын үйл ажиллагаанд итгэх иргэдийн итгэл, даатгуулах сонирхол нэмэгдэнэ.

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

хамгаалах асуудал	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, суртахуун	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгоно.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шүүхийн өмнө маргаан шийдвэрлэх тогтолцоог сайжруулна.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

	нөлөөлөх эсэх			
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө.

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар	
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд бүрэн нийцэх бөгөөд бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй, давхардахгүй болно.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын Тав дахь хэсэгт заасан үе шатанд хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг тандан судлахад:

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй;

Хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй, харин даатгуулагчид хүрэх хүртээмжийг нэмэгдүүлэх буюу эерэг нөлөөтэй;

Даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, даатгалын бүтээгдэхүүний тогтвортой байдлыг хангах, ингэснээр малчид, даатгуулагчид нийт эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх эерэг нөлөөтэй;

Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй бөгөөд Үндсэн хууль болон бусад хуулийн зүйл, заалт, зорилттой нийцэхээр байна.

ЗУРГАА. ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Хөдөө аж ахуйн (тариалангийн болон мал аж ахуйн) даатгалыг хэрэгжүүлдэг өндөр орлоготой орнуудын дийлэнхэд буюу ойролцоогоор 58 хувьд нь хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоо сайн тогтсон байдаг бол бага, дунд орлоготой орнуудын дөнгөж 35 хувь нь ийм бүтээгдэхүүн, хөтөлбөр санал болгодог байна. Хөдөө аж ахуйн даатгалын хүртээмж ялангуяа орлого багатай орнуудад бага 5-8 хувь байна.³

Нүүдлийн мал аж ахуйн даатгалд малын хорогдлоор индекс тогтоон даатгалын бүтээгдэхүүн нэвтрүүлж, хууль эрх зүйн зохицуулалт хийсэн туршлага бусад улс оронд одоогоор байхгүй байна.

Гэсэн хэдий ч судалгаандаа хөдөө аж ахуйн даатгал сайн хөгжсөн орнууд болох Испани, Мексик улсууд болон Монгол Улсын газар зүйн байршил, уур амьсгалтай төстэй Төв Азийн орнууд болох Казакстан, Узбекистан улсууд, харин малын даатгалыг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа Кени улсыг тус тус судлалаа.

Мөн Дэлхийн банкнаас зохион байгуулсан “Төв Азийн орнуудын гамшгийн эрсдэлийн санхүүжилт, даатгал”-ын сэдэвт хэлэлцүүлэгт тавигдсан хөдөө аж ахуйн даатгал болон түүнд оролцох төрийн оролцооны талаарх асуудлын гол агуулгыг товчлон тусгалаа.

Олон улсын туршлагаас харахад хөдөө аж ахуйн салбарыг гамшгийн эрсдэлээс хамгаалахын тулд төр-хувийн хэвшлийн түншлэл чухал үүрэгтэй ба даатгалын механизмаар дамжуулан төрд үзүүлэх төсвийн ачааллыг бууруулж ажиллаж байна. Хөдөө аж ахуйн даатгалыг өргөн цар хүрээ, масштабаар амжилттай хийхэд төр засгийн зүгээс гол үүрэгтэй оролцож, хувийн даатгалын компаниудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, улс орнуудын Засгийн газрууд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн даатгалын нэгдсэн бодлого явуулах
- Хууль эрх зүйн таатай орчныг ойлгомжтой, тодорхой бий болгох
- Гол салбаруудад санхүүгийн болон үйл ажиллагааны дэмжлэгээр хангах болон малчид, тариаланчид, фермерүүдийг мэдлэг мэдээллээр хангах, газар дээр нь очиж хохирлын үнэлгээ, холбогдох ажлуудыг хийж өгч байна.

Гамшгийн эрсдэлийн санхүүжилтгүй бол хамгаалалтын цоорхойг татвар төлөгчдийн мөнгөөс, төсвийн хуваарилалтаар, зээлээр болон олон улсын доноруудын тусламжтайгаар л шийдвэрлэх хэрэг тулгарна.

Харин хөдөө аж ахуйн даатгалыг төрийн татаастай хослуулсан хэрэгжүүлбэл дараах давуу талуудыг бий болгох юм. Үүнд:

- Хөдөө аж ахуй эрхлэгчдийн хувьд хөдөө аж ахуйн даатгалыг үнэ цэнийг нэмэгдүүлнэ. /боломжийн үнээр/
- Хөдөө аж ахуйн зээл олголтыг нэмэгдүүлнэ. /Барьцаа хөрөнгөнд даатгалын гэрээг тооцох замаар/
- Хөдөө аж ахуйн зээлийн эргэн төлөгдөх чадварыг сайжруулдаг. /зээлжих чадварыг хадгалах/

³ Government Support to Agricultural Insurance., World Bank., OLIVIER MAHUL CHARLES J. STUTLEY

- Актуарийн үндсэн дээр тарифаар төлбөр авах боломжийг даатгалын компанид олгоно.
- Даатгалын хамрагдалт нэмэгдэнэ. /их хэмжээний хураамжийн орлого/
- Хөдөө аж ахуйн даатгалын багцын эрсдэл хуваарилалтыг сайжруулна.
- Хөдөө аж ахуй эрхлэгчдийн сөрөг сонголтыг багасгана.
- Төрөөс хөдөө аж ахуй эрхлэгчдийг даатгал худалдаж авахыг дэмжинэ.
- Төр гамшгийн санхүүжилтийн бодит механизмыг бий болгож чадна.
- Улсын төсвийн хөрөнгийг илүү сайн хуваарилахад түлхэц болдог.
- Системийн бус гамшгийн тусламжийг бууруулж, хөдөө аж ахуйн орлого тогтворждог.

Хөдөө аж ахуйн даатгалын салбарт үзүүлдэг төрийн дэмжлэг

/Улс орнуудын төрийн гамшгаас хамгаалах хөтөлбөрүүдийн туршлагаас/

№	Улс орон	ХАА-н даатгалын сантай эсэх	ХАА-н даатгалыг төрөөс дэмждэг хэлбэр				Гамшгийн хохиролд төрөөс татаас өгдөг эсэх
			Даатгуулагч нь төрийн байгууллага	Төрөөс даатгалын хураамжийн татаас өгдөг эсэх	Захиргаа, үйл ажиллагааны зардалд төрөөс татаас өгдөг эсэх	Судалгаа шинжилгээ боловсруулахад дэмжлэг үзүүлдэг эсэх	
1	АНУ	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм
2	Канад	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
3	Испани	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Тийм
4	Португал	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	Тийм
5	Итали	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй
6	Франц	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй
7	Турк	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
8	Энэтхэг	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
9	Өмнөд Солонгос	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	Тийм
10	БНХАУ	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	Тийм

Эх сурвалж: “Disaster Risk Financing and Insurance in Central Asia” conference.
2024.11.12-13

1. Испани Улсын хөдөө аж ахуйн даатгалын тухай

Хөдөө аж ахуйн даатгалын үйл ажиллагааг удирдан чиглүүлэгч

1980 онд Испани Улсын Засгийн газраас нийт мужуудынхаа тариаланчдад сайн дурын үндсэн дээр Засгийн газрын дэмжлэгтэй хөдөө аж ахуйн даатгалын үйлчилгээ үзүүлэх эрхтэй хувийн хэвшлийн хамтын даатгалын Агросегуро (Agroseguro) сангаас даатгалын андеррайтинг үйлчилгээг үзүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн оролцоотой, “Хөдөө аж ахуйн нэгдсэн даатгал” (Испаниар Seguros Agrarios Combinados)” гэсэн нэртэй үндэсний хэмжээний хөдөө аж ахуйн даатгалын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр хууль баталсан.

Агросегуро нь хамтын даатгалын сангийн нэг хэсэг болох даатгалын компаниудын нэрээр болон нэрийн өмнөөс хөдөө аж ахуйн даатгалын менежментийг хариуцдаг. Тиймээс энэ нь даатгалын компани биш, харин менежментийн байгууллага юм.

Энэхүү зорилгынхоо дагуу даатгалын бодлогыг удирдах, боловсруулах, даатгуулагчид болон даатгуулагчаас төлбөрийн баримт олгох, цуглуулах, мөн

даатгуулагчаас нэхэмжлэлийг хүлээн авах, зохицуулалт хийх журам, нөхөн төлбөрийг үнэлж, нөхөн төлөх зэрэг үндсэн үйл ажиллагааг хийдэг. Даатгалын төрөл бүрийн тарифыг тогтоох, даатгалын нөхөн олговрын консорциумаас олгосон давхар даатгалын шимтгэлийн төлбөрийг зохицуулах, Үндэсний газраас олгох татаасыг бүрдүүлэх чиглэлээр статистик судалгаа, актуар судалгаа хийдэг.

Мөн компани нь давхар даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, олон улсын зах зээл дээрх давхар даатгалын компаниудаар дамжуулан удирдах, энэхүү давхар даатгалын хөтөлбөрт хамрагдахыг хүссэн хамтран даатгагчдын нэрийн өмнөөс зохих төлбөрийг төлж, хариуцдаг.

Сайн дурын ба албан журмын даатгал

Испани Улсад үрийн тариалалт, малын даатгал нь *сайн дурын даатгалын* тогтолцоотой.

Даатгалд хамруулах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд

Өнгөрсөн 28 жилийн хугацаанд Агросегуро хөтөлбөрийн төслийг боловсруулж, туршиж, албан ёсоор баталсны үр дүнд 200 гаруй нэр төрлийн үр тариа, малын зарим төрлүүд, ойн аж ахуй, загас, далайн амьтны үржүүлгийн бүтээгдэхүүнүүдийн даатгалын зах зээлийг нэвтрүүлэн хэрэгжүүлсэн. Тус компаний зүгээс маш олон төрлийн үрийн тариалангийн нэрлэсэн эрсдэлийн даатгал (named-peril crop insurance) болон үрийн тариалангийн олон төрлийн эрсдэлийн даатгал (multiple peril crop insurance)-ын үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ үхэр, хонь, ямаан сүргийн даатгал, цэнгэг ус болон далай дээрх тариалалтын даатгалын цогц үйлчилгээг санал болгож байна.

Нөхөн төлбөрийг хохирол гарснаас хойш буюу зохицуулалт хийгдсэнээс хойш 60 хоногийн дараа даатгуулагчид олгодог.

Хүснэгт 1: Хөдөө аж ахуйн даатгалын бүтээгдэхүүнүүд

Үрийн тариалангийн даатгалын бүтээгдэхүүнүүд				Ногоон байгууламж	Ойн аж ахуй
Олон төрлийн эрсдэлийн даатгал	Нэрлэсэн эрсдэлийн даатгал	Тариалалтын өгөөж	Индексжүүлсэн		
Тийм	Тийм, Үйл ажиллагааны өргөн хүрээг хамарсан хамгаалалт	үгүй	Тийм, NDVI	Тийм, зөвхөн тариалалтын хамгаалалт	Тийм, бага талбайг хамарсан ойжуулалт
Малын даатгалын бүтээгдэхүүнүүд					Загас, далайн амьтны үржүүлэг
Бүх эрсдэл	Гэнэтийн осол, малын хорогдол	Тахал өвчин	Бусад	Индексжүүлсэн	Тийм
Үгүй	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Тийм

Эх сурвалж: Дэлхийн Банкны судалгаа.

Төрөөс хөдөө аж ахуйн даатгалд үзүүлэх дэмжлэгийн хэлбэрүүд

Агросегурогийн хөдөө аж ахуйн даатгал нь Испани Улсын Засгийн газар болон мужуудын Засгийн газруудаас санхүүждэг *хураамжийн татаасын*

дэмжлэгийг хөдөө аж ахуй эрхлэгчдэд үзүүлдэг. Хураамжийн татаас олгож Испанид ургадаг бүхий л нэр төрлийн үр тариа, малын төрлүүдийг даатгалд хамруулж байгаагаараа маш онцлогтой юм.


“Испанийн газар тариалангийн нэгдсэн хөтөлбөр” нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн төлөөлөл бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд гурван талт хэлэлцээр хийгдсэн. Үүнд: (1) Испанийн Засгийн газраас ENESA буюу Испани Улсын хөдөө аж ахуйн даатгалын агентлаг болон Сангийн яам, Хөдөө аж ахуйн яамдын төлөөллийн оролцоо; (2) Автономит улс болон мужийн Засгийн газрууд, бэлтгэн нийлүүлэгч нийгэмлэгүүд; (3) Агросегуро сан болон CCS даатгалын компаниуд уг хэлэлцээрийг үзэглэсэн.

Испани Улсын Засгийн газраас хөдөө аж ахуйн даатгалд дараах дэмжлэгүүдийг үзүүлдэг:

- Даатгалын тухай хууль тогтоомж боловсруулах,
- Хөдөө аж ахуй эрхлэгчдийн хөдөө аж ахуйн даатгалын хураамжид татаас олгох,
- CCS давхар даатгалын компаниар дамжуулан хамтын даатгал болон давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх.

Испани Улсад хураамжийн татаас нь хөдөө аж ахуй эрхлэгчдэд хөдөө аж ахуйн даатгалыг сайн дураар сонгон хэрэглэхийг сурталчлан таниулахад бодлогын хувьд маш чухал хэрэглүүр болдог. Агросегуро сангаас даатгалын хураамжийн хувийн актуар тооцооллыг хийж, Засгийн газраас уг тооцоолсон хураамжийн дагуу олгох татаасын хэмжээг тогтоодог. Засгийн газраас нь харилцан ялгаатай хураамжийн хувьтай татаасын тогтолцооны дагуу үрийн тариалангийн төрөл, малын төрөл, даатгалын бүтээгдэхүүний нэр төрлөөр нь тухайлбал даатгалын нэрлэсэн хохирлыг тооцоолж, хураамжийн татаасын хэмжээг тодорхойлдог. Түүнчлэн зорилтод бүлэг болох залуу тариаланчид, олон жил даатгуулсан болон олон төрлийн үрийн тариалан эрхлэгчдэд зориулж даатгалын нийгэмлэгүүдээр дамжуулан борлуулсан даатгалын хэмжээнд үндэслэн хураамжийн нэмэлт татаас олгодог.

Диаграм 1. Хөдөө аж ахуйн даатгалд төр, хувийн хэвшлийн түншлэлийн оролцоо



2. Мексик Улсын хөдөө аж ахуйн даатгалын тухай

Мексик Улсад хөдөө аж ахуйн даатгал 1926 оноос эхэлсэн түүхтэй бөгөөд 1961 онд Засгийн газраас даатгалын агентлагаар дамжуулан "ANAGSA" хөтөлбөрийг хэрэгжүүлсэн ч түүнийгээ халж, 1990 онд *төрийн өмчит үрийн тариалан, малын даатгалын үйл ажиллагааг явуулдаг Агроасемекс компанийг* байгуулсан. Энэхүү компани нь Засгийн газраас олгох хөдөө аж ахуйн даатгалын хураамжийн татаасын тогтолцоог удирдан зохион байгуулах, үндэсний хөдөө аж ахуйн давхар даатгалын компанийн зохион байгуулалттай.

Мексик Улс нь хөдөө аж ахуйн даатгалын төр, хувийн хэвшлийн түншлэлийн оролцоотой Үндэсний хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоотой. Уг тогтолцоонд Испаний хөдөө аж ахуйн давхар даатгалын төрийн өмчит Агроасемекс компани, хувийн хэвшлийн арилжааны даатгалын компаниуд, тус улсын гол онцлогийг бүрдүүлсэн бага хэмжээний хөдөө аж ахуй эрхлэгчдийн байгуулсан хөдөө аж ахуйн даатгалын хамтын сангууд зэрэг хамтын даатгалын компаниуд хамтран оролцдог.

Сайн дурын ба албан журмын даатгал

Мексик Улсад хөдөө аж ахуйн даатгалд *сайн дураар хамрагдах тогтолцоотой* байдаг ч зээл олгохтой уялдуулсан нөхцлүүдийг тусгасан байдаг.

Даатгалд хамруулах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд

Мексикийн зах зээлд үрийн тариалан, малын даатгалын маш олон төрлийн бүтээгдэхүүнүүдийг санал болгодог бөгөөд бүтээгдэхүүнүүдийг дараах 2 ангиллаар авч үздэг. Үүнд:

1. Үрийн тариалан, малын даатгалын бүтээгдэхүүнүүд. Эдгээр бүтээгдэхүүнүүдийг хувийн хэвшлийн арилжааны даатгалын компани, хамтын нийгэмлэг, сангуудаас уламжлалт болон сайн дурын зарчмаар санал болгодог бөгөөд эдгээр бүтээгдэхүүнүүдийг дангаар эсвэл бүхэлд нь даатгалын гэрээнд хамруулж болох нөхөн төлбөрийн нөхцөлтэй. Тус улсын Засгийн газраас энэ төрлийн бүтээгдэхүүнүүдийн даатгалын хураамжийн татаас олгодог.

Мексик Улс нь Латин Америкийн орнуудын дунд хамгийн сайн хөгжсөн, хамгийн том малын даатгалын зах зээлтэй. Малын даатгалд саалийн үнээ, үхэр, гахай, хонь, ямаа, морь, буга, тахиа, зөгий зэрэг нэлээд олон төрлийн мал амьтан хамрагдах боломжтой. Үүний зэрэгцээ сам хорхой, загасны төрөл зүйлийг даатгах загас, далайн амьтдын даатгал гэж байдаг. Малын даатгалын хамрагдалтын хоёр төрөл байдаг. Үүнд: (а) малын осол, хорогдлын даатгал, (b) малын гоц халдварт өвчний даатгалын хамгаалалт. Уламжлалт малын даатгалын хамрагдалтын нийтлэг хэлбэр нь нэгж мал, амьтныг даатгадаг байсан бол 2005 оноос Засгийн газраас хураамжийн татаасын дэмжлэг үзүүлэх замаар мал амьтны их хэмжээний хорогдлыг хариуцах даатгалын шинэлэг хэлбэрт шилжсэн.

Уг даатгалын тогтолцоогоор олон тооны мал сүргийн осол, өвчин, гэмтэж бэртсэн малыг заазлах зэрэг эрсдэлийг даатгадаг. Уг даатгалд төрөөс гаргасан мал, амьтныг нядлах тухай тушаалууд, архаг хууч өвчин, эсвэл тарилга хийж эмчилж болох өвчин хамаарагдахгүй. Энэ төрлийн даатгалын хураамжийн хэмжээ нь маш бага байдаг. Хоёр дахь хамгийн чухал даатгалын төрөл нь олон улсын

хэллэгээр “CSF” гэгдэх Гахайн сонгомол мялзан өвчнөөс сэргийлэх гоц халдварт өвчний даатгалын хамгаалалт юм. “Гахайн сонгомол мялзан өвчний даатгал”-д Гахайн сонгомол мялзан өвчний тархалтаас үүсэн малын хорогдол болон Хөдөө аж ахуйн яамнаас гаргасан тушаалын дагуу зайлшгүй гүйцэтгэх нядалгаанд нөхөн төлбөр олгодог. Энэ төрлийн даатгалыг зөвхөн Гахайн сонгомол мялзан өвчингүй гэж зарлагдсан улс орнуудад санал болгодог аж.

2. Гамшгийн эсрэг даатгалын бүтээгдэхүүнүүд. Энэ төрлийн даатгалын бүтээгдэхүүнүүдийг 2002 онд анх нэвтрүүлсэн бөгөөд үрийн тариалан, малын даатгалд хамрагдах боломжгүй, бага хэмжээний хөдөө аж ахуй эрхлэгчдэд зориулсан байгалийн гамшигт үзэгдлээс үүсэх эрсдэлээс хамгаалах индексжүүлсэн бүтээгдэхүүнүүд юм. Гамшгийн эсрэг даатгалын хөтөлбөрүүдийг “Уур амьсгалын гэнэтийн өөрчлөлтөд өртсөн хөдөө аж ахуй эрхлэгчдийг хамгаалах сан”-аас гаргасан журмын дагуу хэрэгжүүлнэ. Эдгээр томоохон даатгалын хөтөлбөрүүдийг зөвхөн нэг хөдөө аж ахуй эрхлэгчийн даатгалын хамгаалалтын үзүүлэх үйлчилгээ төдийд бус макро түвшинд хэрэгжүүлдэг бөгөөд Холбооны болон муж улсуудын Засгийн газруудаас хувийн хэвшлийн даатгалын компаниудаар дамжуулан “Тариалалтын талбайн индексжүүлсэн даатгалын хөтөлбөр”, Агроасемекс давхар даатгалын компаниар дамжуулан “Үерийн хохирлын даатгал” болон “Normalized Difference Vegetation Index/ буюу ургамлын нормчилсон индекс”-ийг даатгалын хөтөлбөрүүдийн худалдан авалт хийдэг. Гамшгийн эсрэг даатгалын хөтөлбөрүүдэд Холбооны болон муж улсуудын Засгийн газруудаас 100%-ийн татаас олгодог.

2007 онд Агроасемекс компани “Хиймэл дагуулаар тандан судлах бэлчээрийн газрын индексжүүлсэн даатгалын хөтөлбөр”-ийг туршилтын журмаар хэрэгжүүлж эхэлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд үхрийн тэжээлийн хүртээмжийн хэмжээг тогтооход “NDVI” буюу “ургамлын нормчилсон индекс”-ийг ашигладаг.

Хүснэгт 2: Хөдөө аж ахуйн даатгалын бүтээгдэхүүнүүд

Үрийн тариалангийн даатгалын бүтээгдэхүүнүүд				Ногоон байгууламж	Ойн аж ахуй
Олон төрлийн эрсдэлийн даатгал	Нэрлэсэн эрсдэлийн даатгал	Тариалалтын өгөөж	Индексжүүлсэн		
Тийм	Тийм, Үйл ажиллагааны өргөн хүрээг хамарсан хамгаалалт	үгүй	Тийм, NDVI	Тийм, зөвхөн тариалалтын хамгаалалт	Тийм, бага талбайг хамарсан ойжуулалт
Малын даатгалын бүтээгдэхүүнүүд					Загас, далайн амьтны үржүүлэг
Бүх эрсдэл	Гэнэтийн осол, малын хорогдол	Тахал өвчин	Бусад	Индексжүүлсэн	
Үгүй	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Тийм

Эх сурвалж: Дэлхийн Банкны судалгаа.

Төрөөс хөдөө аж ахуйн даатгалд үзүүлэх дэмжлэг

Мексикийн Засгийн газраас хөдөө аж ахуй даатгалд дараах байдлаар дэмжлэг үзүүлдэг. Үүнд:

а) Үрийн тариалан, мал аж ахуй, ойн аж ахуй, загас далайн амьтдын үржүүлгийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг даатгалын компани болон сангуудад даатгалын хураамжийн татаас олгох дэмжлэг;

б) Үндэсний давхар даатгалын Агроасемекс компаниар дамжуулан хөдөө аж ахуйн давхар даатгалын үйлчилгээ;

с) Сургалтад зориулсан татаас. Даатгалын сангуудаас зохион байгуулах сургалтын хөтөлбөрүүдэд зориулсан улсын төсөвлөсөн санхүүжилтийн дэмжлэг үзүүлдэг;

д) Агроасемекс компаниас бүтээгдэхүүний загвар боловсруулж үнэлэх, хохирол тооцох тогтолцоо, үйл ажиллагааны загварыг боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх. Агроасемекс компаний боловсруулсан энэхүү аргачлалыг хувийн хэвшлийн даатгалын компаниуд үйл ажиллагаандаа хэрэглэх юм.

е) “Уур амьсгалын гэнэтийн өөрчлөлтөд өртсөн хөдөө аж ахуй эрхлэгчдийг хамгаалах сан”-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн хүрээнд бага хэмжээний хөдөө аж ахуй эрхлэгчдэд зориулсан гамшгаас хамгаалах даатгалын хамгаалалтад Засгийн газраас 100% татаасын дэмжлэг үзүүлдэг.

3. Казакстан Улсын хөдөө аж ахуйн даатгалын тухай

Казакстан Улс нь 2004 оноос хөдөө аж ахуйн даатгалын албан журмын даатгалын тухай хуулийг баталж, олон төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг хэрэгжүүлсэн байна. Уг хуулиар гамшгаас хамгаалах зорилгоор төрөөс 50 хувийн татаас өгч байсан байна. 2005-2010 онуудад нийт тариалангийн талбайн 75-аас дээш хувь нь даатгуулсан байв.

2018 оноос цахим платформ (Qoldau.kz)-ийг бүх хөдөө аж ахуй эрхлэгчдийг хамруулан нэвтрүүлсэн.

Гэвч олон төрлийн даатгалын бүтээгдэхүүн нь амжилттай хэрэгжиж чадаагүй бөгөөд 2020 онд хөдөө аж ахуйн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, сайн дурын даатгалын төрөлд шилжсэн. Ингэхдээ хуулийг товч тодорхой болгож, цөөн тооны даатгалын бүтээгдэхүүнийг даатгах тогтолцоотой болсон байна.

Газар тариалангийн болон малын даатгалыг тус улсын Хөдөө аж ахуйн зээлийн корпорацийн хамтын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлдэг. Төрөөс даатгалын хураамжийн 50 хувийг төлдөг байсан бол 2020 оноос татаасын хэмжээ 80 хувь болж өссөн байна.

Шинэ цахим платформ “Qalqan.Kezekte.kz”-ийг хөгжүүлж, бүх хөдөө аж ахуй эрхлэгчдийг хөдөө аж ахуйн даатгалын мэдээллийн үйлчилгээгээр хангадаг. Даатгалын бүх оролцогчид цахим дижитал гарын үсэг ашиглан Kezekte.kz платформ дээр бүртгүүлэн, даатгалаа хийлгэдэг. Даатгалын бүх үйл явц онлайнаар явагддаг. Цахим платформ дахь хувийн дансанд фермер даатгалын субъект болох даатгалын компанийг сонгож, ойролцоогоор 6 хувийн хураамж төлдөг, үүнийн 80 хувийг төрөөс хариуцдаг байдаг. 4 даатгалын компанийн хөдөө аж ахуйн даатгалын үйлчилгээг үзүүлдэг.

Свисс Ре /Swiss Re/ олон улсын давхар даатгалын компанид давхар даатгуулсан бөгөөд нөхөн төлбөрийг хохирол болсны дараа 20 хоногт даатгуулагчдад олгодог байна.

Казакстан Улсад сүүлийн 4 жил ган болон үерийн эрсдэл тулгарч хөдөө аж ахуйн салбарт их хэмжээний хохирол амсжээ.

Сайн дурын ба албан журмын даатгал

Казакстан Улсын хөдөө аж ахуйн даатгал нь *сайн дурын даатгалын* тогтолцоотой.

Даатгалд хамруулах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд

Газар тариалангийн даатгал нь илүүдэл чийгийн эсрэг талбайн индексийн даатгал, гангаас хамгаалах талбайн индексжүүлсэн даатгал, үхрийн төрөл бүрийн өвчин, ослоос хамгаалах даатгал, морь, хонины даатгал, гахай, тахианы даатгал, жимс жимсгэнийн даатгалын бүтээгдэхүүнүүдтэй.

Төрөөс хөдөө аж ахуйн даатгалд үзүүлэх дэмжлэг

Төрөөс хөдөө аж ахуй эрхлэгчдэд бүх төрлийн даатгалын бүтээгдэхүүнд хамрагдахад даатгалын 80 хувийн хураамжийн татаас өгдөг.

4. Узбекистан Улсын хөдөө аж ахуйн даатгалын тухай

Узбекистан Улсын хөдөө аж ахуйн даатгалыг “Үндсэн хөдөө аж ахуйн даатгалын компани – Узагросургурта ХК” явуулдаг бөгөөд 95% нь төрийн өмчит юм.

Даатгуулагчид нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид, тариаланчид, ЖДҮ эрхлэгчид болон малчид байдаг.

Даатгалын төрөл нөхөн төлбөр дээр үндэслэдэг тариалангийн болон мал аж ахуйн уламжлалт даатгалын бүтээгдэхүүнүүд байдаг. 2020 онд даатгалын хамгаалалт – 1,5 сая хувь хүн болон аж ахуйн нэгжүүдтэй даатгалын гэрээ байгуулж, 178,2 тэрбум узбек.сом буюу 13,9 сая ам.долларын даатгалын хураамжийн орлого төвлөрүүлснээс 91,3 тэрбум узбек.сом 7,2 сая ам.долларын даатгалын нөхөн төлбөрийг төлсөн байна. 2023 оноос эхлэн олон улсын давхар даатгалын компани, Дэлхийн банктай хамтран индексжүүлсэн даатгалыг нэвтрүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар хөдөө аж ахуйн салбарын даатгалын үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомжийн үндсэн актууд нь: Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 2-р сарын 25-ны өдрийн 1713 тоот зарлиг. “Узагросургурта” төрийн өмчит хувьцаат даатгалын компанийг байгуулах тухай;

Сүүлийн жилүүдэд чанаргүй малын эм хэрэглэж, төрөл бүрийн малын халдварт өвчин ихэссэний улмаас мал олноор хорогдсон байна. Үүнээс болж мал аж ахуй эрхлэгчдэд их хэмжээний хохирол амсаж байна. Мөн энэ нь малын үнэд нөлөөлдөг. Ийм нөхцөлд алдагдлыг нөхөх боломжийн механизм бол даатгал юм. Мал аж ахуйн салбарыг бүрэн хөгжүүлэх нь дотоодын хэрэглээний зах зээлийг дүүргэх, улс орны эдийн засагт томоохон хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

5. Кени Улсын хөдөө аж ахуйн даатгалын тухай

Кени Улсад өнгөрсөн хугацаанд гамшгийн эрсдэл гангийн улмаас бод малын 75 орчим хувийг хорогдуулж, малчид, тэдний гэр бүл, нийт ард иргэдийн амьжиргаанд маш ихээр нөлөөлөн их хэмжээний хохирлыг дагуулжээ.

2015 оны 10-р сард Африк Улсын Засгийн газар Дэлхийн банкт хамтран малын даатгалын төсөл болох “Кенийн Малын Даатгалын Хөтөлбөр (KLIP)”-ийг Кенийн хойд хэсгийн хоёр мужид амжилттай туршсан байна.

Хөтөлбөр нь алслагдсан бүс нутгийн бэлчээрийн малчдыг хамгаалах зорилгоор хиймэл дагуулын дата мэдээллийг ашигладаг бэлчээрийн индексийн даатгалыг /pasture insurance/ хэрэгжүүлсэн. Хиймэл дагуулаас NDVI /Normalized Difference Vegetation Index/ буюу ургамлын ногоорлын индексийг ашиглаж газрын өнгийг хэмжих замаар тодорхой бүс нутгийн бэлчээрийн нөхцөл байдлыг үнэлдэг. Ногоон нь сайн, шар нь маш хуурай гэх мэтээр цахим платформ дээр ялган харуулдаг.

Даатгуулагч тодорхой босгод хүрмэгц нэг удаагийн төлбөрийг автоматаар авч, үхэр, ямаа, тэмээ зэрэг малаа тэжээх, усаар хангах боломжийг олгодог. Малчдын орлогын гол эх үүсвэр нь ихэвчлэн мал байдаг тул эрсдэл учрахад тэдний амьжиргааны эх үүсвэр доройтно.

2015 оны 10-р сард эхлүүлсэн KLIP туршилт нь Важир, Туркана хоёр хошууг хамарч, 5000 өрхийн малыг хамгаалсан. Одоогийн байдлаар Важир хошууны 275 нүүдлийн мал аж ахуй эрхлэгч даатгалын төлбөрөө авсан байна. Кенийн Засгийн газраас өлсгөлөнгийн аюулгүй байдлын сүлжээ хөтөлбөрт бүртгэлтэй малчдын хураамжийг 100 хувь санхүүжүүлдэг бөгөөд нэг өрх нь таван малаа даатгуулдаг байна. Мөн өөрсдийн зардлаар нэмэлт мал даатгуулах боломжтой. Орон нутгийн даатгалын компаниуд энэхүү төсөлд хамтран ажилладаг. Энэхүү төслийг мөн Олон улсын мал аж ахуйн судалгааны хүрээлэн, Swiss Re компани дэмжиж ажиллаж байна.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан даатгалын салбарыг хөгжүүлэх, гамшгийн аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилттой уялдуулан малчид, даатгуулагчид зудын гамшигт үзэгдэлд сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, даатгалын хүртээмжийг сайжруулах, даатгалын салбарын оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах зорилгын хүрээнд урьдчилан тандан судлах тайланг боловсруулсан бөгөөд харьцуулалтын үр дүнгээр “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар нь зорилгод хүрэх боломжтой оновчтой хувилбар гэж дүгнэж байна.

**МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН
НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ. Үүнд:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох;
- Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- Үр дүнг баримтжуулах, үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- Зорилгод хүрэх байдал;
- Практикт хэрэгжих боломж;
- Ойлгомжтой байдал;
- Зардал
- Харилцан уялдаа;

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

Зорилгод хүрэх байдал:

Хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь тус хуулийн төсөлд тавьсан зорилго нь тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох, зорилгод хүрэх байдалд дүн шинжилгээ хийх учир хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Практикт хэрэгжих боломж:

Хуулийн төсөлд практикт хэрэгцээ, шаардлагатай байгаа хэд хэдэн шинэ зохицуулалтуудыг тусгасан бөгөөд тэдгээр зохицуулалтууд нь хэрэгжих боломжтой эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Гамшгийн эрсдэлийн үед МИД-ын нөхөн төлбөрийг малчдад урьдчилж олгох, малын хорогдлын босго үзүүлэлтийг тогтоох асуудлыг зохицуулах, гамшигт үзэгдлийн улмаас даатгуулсан малчдад бүрэн нөхөн төлбөр олгох, давхар даатгалын компанийн эрсдэл даах чадамжид сөргөөр нөлөөлөх үед төр дахин чадавхжуулах дэмжлэг үзүүлэх эрхзүйн орчныг бий болгосон болно.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийг 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдөр баталсан. Үндэсний давхар даатгал /ХК/ компанийн хэрэгжүүлэх чиг үүрэг, эрхлэх үйл ажиллагааны цар хүрээ анх байгуулагдсан цагаас өргөжин нэмэгдсэнтэй холбоотойгоор компанийн өнөөгийн болон хэтийн үйл ажиллагааг

хуулийн зохицуулалтад уялдуулах зайлшгүй шаардлагын улмаас холбогдох өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгасан.

Ойлгомжтой байдал:

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүйн найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Зардал:

Хуулийн төсөлд шинээр тусгасан зохицуулалтуудыг хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага тухайн үүрэг гүйцэтгэхтэй холбогдон гарах мөнгөн зардлыг тооцох, хуулийн төслийн үйлчлэлд хамаарах этгээдэд ачаалал үүсэх эсэхийг тогтоох шаардлагатайг харгалзан зардал тооцох шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Харилцан уялдаа:

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн этгээдүүдийн чиг үүрэг, давхардал зөрчилдөөнгүй байх шаардлагатай.

Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:

Хуулийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, хуулийн этгээдэд ачаалал, хүндрэл үүсгэх эсхүл төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зэрэг зохицуулалт шинээр тусгагдаагүй учир “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн холбогдох зохицуулалтууд	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч этгээдүүдийн өгсөн тайлбар, ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29,

		зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
4	Зардал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үйлчлэлд хамаарах этгээдийн зардлыг тооцон гаргах
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1, Аргачлалын 4.10-т заасан шаардлага хангасан эсэх

Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорилоо.

Үүний дагуу хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.

МИД-ын босго үзүүлэлт нь малчдын даатгалд хамрагдах эсэхийг тодорхойлох үндсэн шалтгаан болж байгаагаас шалтгаалан босго үзүүлэлтийг хуульд тусгайлан заахгүйгээр актуар тооцоололд үндэслэн тогтоож байх зохицуулалтыг хуулийн төслийн 7 дугаар зүйлд тусгасан байгаа нь тус даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгал үр өгөөжтэй байх, МИД-ын тогтолцоог урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх бодлогод нийцсэн бөгөөд МИД-ын хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгыг хангаж байна.

Малчдад нөхөн төлбөрийг урьдчилан олгох шинэ зохицуулалтыг хуулийн төслийн 12 дугаар зүйлд тусгасан байна. Гамшгийн эрсдэлийг хохирол багатай даван туулах, малчдын амьдралын баталгааг хамгаалах, даатгал үр дүнтэй бөгөөд хэрэгцээтэй үедээ малчид нөхөн төлбөрөө авч эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуулийн зорилгыг хангаж байна.

Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Хуулийн төсөлд шинээр тусгасан зохицуулалт нь “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган даатгалын үйл ажиллагаанд оролцогчдоос ирүүлсэн хуулийн хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээл, санал, өгсөн тайлбарт үндэслэн хуулийн зохицуулалт болон бодит байдлын үл нийцлийг судлах, бодит байдалд хэрэгжих боломжтой эсэх, хуулийн төслийг хэрэгжүүлэгч этгээдүүд хуулийн төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодруулахыг зорилоо.

Хүснэгт-2

Д/д	Хуулийн төслийн заалт	Практикт хэрэгжих боломж
1	7 дугаар зүйл. Босго үзүүлэлтийг тогтоох 7.2.Энэ хуулийн 7.1-д заасан босго үзүүлэлтийг 18.1-д заасан давхар даатгалын компанийн саналыг харгалзан шинэчлэн тогтооно.	Судалгаагаар МИД-ын босго үзүүлэлт нь малчдын даатгалд хамрагдах эсэхийг тодорхойлох үндсэн шалтгаан болж байгаа нь тогтоогдсон. Босго үзүүлэлтийг хуульд тусгайлан заахгүйгээр малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанд оролцогчдын

		үндэслэл бүхий саналыг харгалзан шинэчлэн тогтоосноор малчдын даатгалд хандах итгэл үнэмшлийг нэмэгдүүлж, даатгалын үр өгөөжийг хүртэх, МИД-ын хуулийн хэрэгжилтэд нөлөөлөх чухал ач холбогдолтой байна.
2	12 дугаар зүйл. Нөхөн төлбөр 12.2. Даатгагч нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгож болно. 12.4. Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын энэ хуулийн 6.1-д заасан хугацаанаас өмнө гаргасан мэдээллийг үндэслэн даатгагч 4.1.8-д заасан гэрээний хугацаанд нөхөн төлбөрийг нэг удаа урьдчилан олгож болно.	Гамшигт үзэгдэл болж байх үед малчдад нөхөн төлбөрийг урьдчилан олгосноор гамшгийн эрсдэлийг хохирол багатай даван туулах даатгалын үр шимийг хүртэх, даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх гол ач холбогдолтой юм. МИД-ын нөхөн төлбөрийг малчдад урьдчилж олгохдоо Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын улирал болон сараар гаргадаг мэдээнд үндэслэн босго үзүүлэлтийг 50 хувиас дээш давах нь тодорхой болсон тохиолдолд нөхөн төлбөрийг урьдчилан олгож, хагас жилийн түүвэр судалгааны дүн мэдээ эцэслэн гарсны дараа нөхөн төлбөрийг эцэслэх учир актуар тооцоолол, мэргэжлийн байгууллагуудын мэдээлэл, саналд үндэслэн эрх бүхий мэргэжлийн этгээдүүдийн төлөөллийн бүрэлдэхүүн хамтран батлах боломжтой болсноор индексжүүлсэн даатгалын системийн тогтвортой хөгжилд эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Даатгалын тухай хуулийн 10.1.5-д заасны дагуу Даатгуулагч нь даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ИХ-ийн 439.5-д үүнтэй холбогдон гарсан зардлыг даатгагч хариуцах үүргийг тус тус хүлээсэн. Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс мал хорогдох эрсдэлээс хамгаалах, малчдын амьдралын баталгааг хангах МИД-ын хуулийн үндсэн зорилгод нийцэх мөн даатгал үр дүнтэй бөгөөд цаг үеэ олсон оновчтой байх, хуульд заасан даатгуулагч, даатгагчийн эрх үүрэгт бүрэн нийцэх практикт хэрэгжих боломжтой юм.

Үнэлгээ:

Хуулийн төсөлд тусгасан дээрх шинэ зохицуулалтууд нь даатгалын үйл ажиллагаанд оролцогчдын санал хүсэлт, хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэсэн, бодит хэрэгцээ шаардлагад тулгуурласан бөгөөд хуулийн

хэрэгжилтийг хангах этгээд байгаа тул хуулийн зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх боломжтой байна.

Ойлгомжтой эсэх:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боосруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Хүснэгт 3.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Шаардлага хангасан эсэх
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Хуулийн төсөл нь уг шаардлагыг хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Хуулийн төсөл нь уг шаардлагыг хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хүрээнээс хальсан асуудал тусгаагүй байна.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх	Хуулийн төсөл нь уг шаардлагыг хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Хуулийн төсөл нь уг шаардлагыг хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Хуулийн төсөл нь уг шаардлагыг хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Хуулийн төсөл нь уг шаардлагыг хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Хуулийн төсөл нь уг шаардлагыг хангасан.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг

	хангасан
--	----------

Зардал:

Өнгөрсөн 46 жилийн эрсдэлийн дунд болон дээд түвшний хохирлын харьцааны түүхэн дата мэдээлэлд үндэслэн дунд болон дээд түвшинд учирч болзошгүй эрсдэлийг тооцоолоход малын индексжүүлсэн даатгалын хураамжийн орлого болон даатгалын нийт үнэлгээний хэмжээнээс хамааран гарах нөхөн төлбөрийн хэмжээ дараах байдалтай байна.

Хүснэгт-4

Дунд түвшнээс гарч болзошгүй нөхөн төлбөрийн хэмжээ /төгрөг/

Хувилбар	Хураамжийн орлого	Гарах нөхөн төлбөрийн хэмжээ
1	3 тэрбум	8,659,635,918.70
2	4 тэрбум	11,546,181,224.93
3	5 тэрбум	14,432,726,531.17

Хүснэгт-5

Дээд түвшнээс гарч болзошгүй нөхөн төлбөрийн хэмжээ /төгрөг/

Хувилбар	Даатгалын үнэлгээ	Хураамж	Гарах нөхөн төлбөрийн хэмжээ
1	78,804,965,709.775	3 тэрбум	3,451,657,498.09
2	105,073,287,613.033	4 тэрбум	4,602,209,997.45
3	131,341,609,516.291	5 тэрбум	5,752,762,496.81

Олон улсын давхар даатгагчийн хариуцах хэсэг өөрчлөгдөхгүй гэж таамаглахад Үндэсний давхар даатгал ХК-аас нөхөн төлбөрт зарцуулж болзошгүй нийт зардлын хэмжээг тооцов.

Хүснэгт-6

Нийт нөхөн төлбөрийн зардал /төгрөг/

Хувилбар	Нийт нөхөн төлбөрийн хэмжээ /B=A+B/	Олон улсын давхар нийт даатгагчийн хариуцлага /Г/	Үндэсний давхар даатгал ХК-ийн нийт хариуцлага /Д=В-Г/
1	12,111,293,416.79	5,058,432,995.93	7,052,860,420.86
2	16,148,391,222.38	6,744,577,327.91	9,403,813,894.47
3	20,185,489,027.98	8,430,721,659.89	11,754,767,368.09

Дээрх тооцооллоос харахад Үндэсний давхар даатгал ХК-аас гарч болзошгүй хамгийн их зардал 11,754,767,368.09 төгрөг байна. Монгол Улсад 2 ба түүнээс дээш жил дараалан зудын гамшигт үзэгдэл тохиолдоход Үндэсний давхар даатгал ХК-ийн алдагдлаас хамгаалах санд ирэх ачааллыг урьдчилан тооцов. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийг гуравдугаар хавсралтаар баталсан “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-д заасны дагуу Үндэсний давхар даатгалын компани ХК-ийн Алдагдлаас хамгаалах санд 15.0 тэрбум төгрөг байна.

МИД-ын 2024 оны борлуулалтын орлого 3,728,672,184.95 төгрөг бөгөөд 1978-2024 он хүртэлх хорогдлын дата мэдээллээс харахад хамгийн их хохирол

2010 онд тохиолдож байсан. Хэрэв энэ хохирол 2025 онд дахин давтагдана гэж таамаглавал эрсдэлийн дунд түвшинд **11,393,952,552.64** төгрөг, эрсдэлийн дээд түвшинд **3,815,847,512.84** төгрөгийн нөхөн төлбөр учирч болзошгүй байна.

Үндэсний давхар даатгал ХК нь 2024 онд учирсан зудын гамшигт үзэгдлээс нийт 16.8 тэрбум төгрөгийн хохирол учирснаас өөрсдийн хариуцах хэсэг болох 14.5 тэрбум төгрөгийг нөхөн төлсөн бөгөөд эрсдэлийн дунд болон дээд түвшний нөөц сангуудаа шавхсан тул 2025 онд учирч болзошгүй хохирлыг дараах байдлаар санхүүжүүлэхээр байна.

Хүснэгт 7. 2024 оны борлуулалтаас 2025 онд учирч болзошгүй хамгийн их нөхөн төлбөр (төгрөгөөр)

Хохирлын жил		2025 он
Нийт даатгалын хураамжийн орлого		3,728,672,184.95
Эрсдэлийн дунд түвшин	Хамтын эрсдэлийн сан (нөөц сангийн хамт)	1,677,902,483.23
	Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан 1	349,577,455.43
	Олон улсын давхар даатгагч	4,847,273,840.44
	Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан 2	-
	Алдагдлаас хамгаалах сан	4,519,198,773.55
	Нийт нөхөн төлбөр	11,393,952,552.64
Эрсдэлийн дээд түвшин	Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан 1	-
	Олон улсын давхар даатгагч	1,563,125,920.20
	Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан 2	-
	Алдагдлаас хамгаалах сан	2,243,670,538.52
	Нийт нөхөн төлбөр	3,815,847,512.84
Алдагдлаас хамгаалах санд ирэх ачаалал		6,768,203,871.90

МИД-ын 2025 болон 2026 оны борлуулалтын орлогуудад харгалзах 2026 болон 2027 онуудад учирч болзошгүй хохирлын хэмжээг хүснэгтэд харуулав. Компани эрсдэлийн дунд болон дээд түвшний нөөц сангаа хангалттай хэмжээнд нэмэгдүүлж чадаагүй тохиолдолд Алдагдлаас хамгаалах санд ирэх ачаалал дээрхтэй адил байхаар байна.

Хүснэгт-8

2025 болон 2026 оны борлуулалтаас учирч болзошгүй хамгийн их нөхөн төлбөр /төгрөг/

Хохирлын жил		2026 он	2027 он
Таамаглаж буй даатгалын хураамжийн орлого		3,099,622,070.11	4,443,728,289.08
Эрсдэлийн дунд түвшин	Хамтын эрсдэлийн сан (нөөц сангийн хамт)	1,394,829,931.55	1,999,677,730.08
	Дунд түвшний эрсдэлээс	238,670,899.40	342,167,078.26

Эрсдэлийн дээд түвшин	хамгаалах сан 1		
	Олон улсын давхар даатгагч	4,029,508,691.15	5,776,846,775.80
	Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан 2	-	-
	Алдагдлаас хамгаалах сан	3,808,712,594.03	5,460,305,648.95
	Нийт нөхөн төлбөр	9,471,722,116.13	13,578,997,233.09
	Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан 1	-	-
	Олон улсын давхар даатгагч	1,278,702,825.67	1,983,678,889.79
	Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан 2	-	-
	Алдагдлаас хамгаалах сан	1,835,416,981.06	2,847,321,399.64
	Нийт нөхөн төлбөр	3,114,119,806.72	4,831,000,289.43
Алдагдлаас хамгаалах санд ирэх ачаалал		5,644,129,575.09	8,307,627,048.59

Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийн бүх заалтын хүрээнд үзэхээр тооцлоо. Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэлснийг Хүснэгт 4-с үзнэ үү.

Хүснэгт 10.

Д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Энэ шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Бүрэн нийцэж байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Бусад хуулийн заалттай бүрэн нийцэж байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Давхардал илрээгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй	Орхигдуулсан зохицуулалт илрээгүй.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг	Үгүй	Давхардал илрээгүй.

	давхардуулан тусгасан эсэх		
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Тийм	Хуулийн төсөлд малын хорогдлын босго үзүүлэлтийг тусгай зөвшөөрөлтэй, тусгайлсан чиг үүрэг бүхий давхар даатгалын компанийн саналыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлах боломжтой болсон.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай тусгасан эсэх	Тийм	Тусгай зөвшөөрлийн зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй	Хязгаарласан зохицуулалт илрээгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөл жендерийн тэгш байдлыг хөндөөгүй болно.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Өрсөлдөөнийг хязгаарласан зохицуулалт илрээгүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хуулийн төсөлд авлига хүнд, суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусаагүй байна.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан эсэх	Тийм	Тухайн хуулийг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, хүн хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуулиар зохицуулахаар тус тус тусгасан байна.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт, өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах Дүгнэлтийг хийж, Зөвлөмж боловсрууллаа.

ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төсөлтэй танилцаж, үр дагавар үүсгэж байгаа гол ач холбогдолтой гэсэн заалтуудыг сонгох болон бүхэлд нь авч үзэж, аргачлалд заасан үе шат бүрийн дагуу хийгдсэн ажиллагааны хүрээнд энэхүү дүгнэлтийг гаргаж байна:

1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр: Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа эсэх болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалт хангаж, илэрхийлж чадахаар бүрэн, гүйцэт томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд зорилгодоо хүрэх шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

2.Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтээр: Хуулийн төсөлд тусгагдсан шинэлэг зохицуулалтуудыг онцгойлон авч үзэхэд тухайн зохицуулалттай холбоотой хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд түүнийг хэрэгжүүлэх этгээд тодорхой, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж байгаа тул практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

3.Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр: Хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан гэж үзэж байна.

4.Зардал тооцох шалгуур үзүүлэлтээр: Хуулийн төсөлд тусгагдсан шинэлэг зохицуулалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тодорхойлж, үүсэх ачааллыг бууруулах шалгуур үзүүлэлтийн зорилгыг хангасан гэж үзэж байна.

5. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр: Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан. Харилцан уялдаатай байдлыг хангасан байна.

ЗӨВЛӨМЖ

Хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд үндэслэн энэхүү хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, танилцуулга, төслийн үр нөлөөг тооцсон үнэлгээний тайлан, зардлын тооцоо зэрэг холбогдох бүрдлийн хамт уг хуулийн төслийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх боломжтой байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Иргэний хууль;
- Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль;
- Даатгалын тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол;
- Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл;

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

1. Ерөнхий зүйл

Малын индексжүүлсэн даатгал /МИД/-ын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг /цаашид “хуулийн төсөл” гэх/ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах төрөл тус бүрээр тооцлоо. Үүнд:

1. Хуулийн этгээдийн зардал
2. Иргэнд үүсэх зардал

Тус хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон төрийн байгууллагаас гарах зардал байхгүй тул тооцоогүй болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.3-т “Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.” гэж заасны дагуу “Малчны тухай хууль”-д “12.3.5-д Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан байх.” гэсэн нэмэлт зохицуулалт орж байгаатай холбогдуулан иргэнд үүсэх зардлыг дараах байдлаар тооцооллоо.

Нэг иргэнд учрах зардлын хэмжээг тооцоолохдоо жишээ болгон малын индексжүүлсэн даатгалд даатгуулаагүй болон даатгуулсан тооцооллыг хийсэн.

Тооцооллыг хийхдээ 2023-2024 оны нэг малчны төлдөг дундаж хураамжийн дүнг үндэслэн тооцоолсон ба малчинд олгох нөхөн төлбөрийг тооцоолохдоо 2024 оны Үндэсний статистикийн хорооны хагас жилийн мал тооллогын дүн мэдээнд үндэслэн нөхөн төлбөрийг тооцоолсон болно.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын малчин А нь “Малын индексжүүлсэн даатгал”-д 5 төрлийн малаа доорх байдлаар даатгуулсан.

Үзүүлэлт	Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Нийт
Малын тоо	161	154	28	15	358
Хураамж	53,000	60,000	61,000	26,000	200,000

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хорогдлын хувь малын төрөл тус бүрээр:

Хонь	Ямаа	Үхэр	Адуу
75.79	65.55	58.04	29.18

А малчны авах нөхөн төлбөр:

Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Нийт
1,222,000	1,041,000	830,000	307,000	3,400,000

Малчин А 4 төрлийн малдаа даатгалын хураамж болох 200,000 төгрөг төлөөд 3,400,000 төгрөгийн нөхөн төлбөр авна.

Малчин арилжааны банкнаас нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээл авах, үйлдвэрлэлдээ чанарын өөрчлөлт гаргах, байгальд ээлтэй, тогтвортой үйл ажиллагаа эрхлэхэд төрөөс үзүүлж буй дэмжлэгийг хүртэхэд гарах зардал дунджаар 200,000 төгрөг байхаар байна.

3. Ашигласан дата мэдээлэл болон таамаглал

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 7 болон 8 дугаар зүйлд сумын малын хорогдлын босго үзүүлэлтийг тогтоох болон даатгалын эрсдэлийн түвшинг тогтоосон юм. МИД-ын эрсдэлийн дунд түвшин буюу сумын малын хорогдлын 6 хувиас 30 хувь хүртэл арилжааны даатгалын түвшин бөгөөд энэ түвшин хүртэл л малчид даатгалын хураамж төлдөг. Харин эрсдэлийн дээд түвшин буюу 30 хувиас давсан түвшин нь гамшгийн эрсдэлийн түвшин бөгөөд Засгийн газрын хариуцах түвшин юм. Энэ талаар 2005 оноос хэрэгжиж эхэлсэн МИД төслийн мэргэжлийн зөвлөхүүд судалгаа хийж Засгийн газар энэхүү эрсдэлийг хариуцах нь зөв гэж үзсэн байна. /Зураг 1/

Зураг 1 Эрсдэлийн түвшинг хариуцах этгээдүүд

Иймд 1976 оноос хойшхи нийт 46 жилийн сумын малын хорогдлын дүн мэдээнд үндэслэн МИД-ын эрсдэлийн дунд болон дээд түвшний хохирлын харьцааны мэдээллийг боловсруулж, Хавсралт 1-д харуулав.

Дунд түвшний эрсдэлийг хохирлын харьцаагаар 60 хувь давсан 130 хувийг нь олон улсын давхар даатгагчид шилжүүлж, бусад эрсдэлийг Үндэсний давхар даатгал ХК хариуцах буюу дунд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн тооцоолол хийв. Харин 10 жилд 1 удаагийн давтамжтай учирч болох эрсдэлийг Үндэсний давхар даатгал ХК хариуцахаар, 25 жилд 1 удаагийн давтамжтай учирч болох эрсдэлийг олон улсын давхар даатгалд шилжүүлэхээр дээд түвшний эрсдэлийг тооцсон /Г/.

МИД-ын 2025 оны борлуулалтын орлогыг 2014 - 2024 оны борлуулалтын орлогуудын дундажтай тэнцүү байна гэж таамаглахад 3,099,622,070.11 төгрөг байхаар байна. Харин борлуулалтын орлогын түүхэн дата мэдээлэлд үндэслэн түүний дундаж болон стандарт хазайлтыг ашиглан 95 хувийн итгэх түвшинд хамгийн их борлуулалтын орлогыг таамаглахад 4,443,728,289.08 төгрөг болохоор байна. (Хүснэгт 1).

Хүснэгт 1 МИД-ын үнэлгээ болон хураамж, төгрөгөөр

Он	Даатгуулсан малын нийт үнэлгээ	Малчны төлсөн хураамжийн хэмжээ
2014	30,019,031,531.83	1,374,088,230.00
2015	27,729,337,218.14	1,313,446,950.47
2016	39,561,354,021.09	1,774,078,180.87
2017	55,022,877,851.47	2,329,114,961.80

2018	95,576,879,255.41	3,462,698,777.46
2019	114,874,097,489.99	3,845,685,067.08
2020	99,868,378,481.89	3,478,513,328.02
2021	120,805,633,656.12	3,921,972,274.61
2022	117,977,117,792.27	3,911,861,006.11
2023	149,082,650,669.64	4,965,484,303.54
2024	106,335,096,612.25	3,718,899,691.30
Дундаж	86,986,586,780.01	3,099,622,070.11
VaR (95%)	134,944,142,162.88	4,443,728,289.08

4. Хуулийн этгээдийн зардлын тооцоолол

4.1. Үндэсний давхар даатгал ХК-ийн гүйцэтгэх үүрэг

Хууль тогтоомжийн зохицуулалт	
12 дугаар зүйл. Нөхөн төлбөр	
12.2. Даатгагч нөхөн төлбөрийг энэ хуулийн 12.4-т зааснаас бусад тохиолдолд хэсэгчлэн олгохыг хориглоно.	
12.4. Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын энэ хуулийн 6.1-д заасан хугацаанаас өмнө гаргасан мэдээллийг үндэслэн даатгагч энэ хуулийн 4.1.8-д заасан гэрээний хугацаанд нөхөн төлбөрийг нэг удаа урьдчилан олгож болно.	

Үндэсний давхар даатгал ХК нь МИД-ын тухай хуульд заасны дагуу хорогдлын хэмжээ босго үзүүлэлтийг давсан үед даатгуулагчид буюу малчдад нөхөн төлбөр олгох үүрэгтэй. Дээрх зохицуулалтын дагуу нөхөн төлбөрийг урьдчилан олгох нь даатгалын ашиг тусыг нэмэгдүүлэх, хүртээмжийг өсгөх, малын хорогдлыг тодорхой хэмжээгээр бууруулж чадна гэж үзэж байна.

МИД-ын нөхөн төлбөрийг олгохдоо Үндэсний статистикийн хорооноос хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааг зохион байгуулж, малын хорогдлын дүн мэдээ гарсны дараа малчдад олгох нөхөн төлбөрийг тооцоолж, тухайн оны 10 сард нөхөн төлбөрийг олгодог. Энэхүү хугацаа нь зудын эрсдэл болж дууссаны дараа буюу даруй 8 сарын дараа нөхөн төлбөр олгогдож байгаа нь зудад өртсөн малчид гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даван туулах, даатгалын үр шимийг хүртэх боломжийг бууруулж байгаа юм.

Иймд МИД-ын нөхөн төлбөрийг малчдад урьдчилж олгох, ингэхдээ Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээнд үндэслэн босго үзүүлэлтийг 50 хувиас дээш давах нь тодорхой болсон тохиолдолд нөхөн төлбөрийг урьдчилан олгоно. Нөхөн төлбөр урьдчилан олгох нөхцөл, шаардлагыг Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасан Хамтын эрсдэлийн сангийн тухай журамд тусгана. Нөхөн төлбөрийн урьдчилж олгосноор малчид гамшгийн эрсдэлийг хохирол багатай даван туулах, даатгалын үр шимийг хүртэх, даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

4.2. Дунд түвшний нөхөн төлбөрийн зардлын тооцоолол

Дунд түвшинд учирч болзошгүй эрсдэлийг тооцоолохдоо 1978-2024 оны буюу өнгөрсөн 46 жилийн хорогдлын мэдээнд үндэслэн ирээдүйд гарах нөхөн төлбөрийн хэмжээг болзошгүй хамгийн их даатгалын хураамжийг тооцоолж, хохирлын харьцааг гаргасан. Хохирлын харьцааны нягтын функцийн 1 хувийн итгэлцлийн түвшинд буюу VaR-ийн 0.99 түвшин нь 288.65 хувь байна. Өөрөөр хэлбэл 99.0 хувийн итгэх түвшинд хохирлын харьцаа 288.6 хувиас ихгүй байна. МИД-ын хураамжийн орлогын хэмжээнээс хамааран гарах нөхөн төлбөрийн хэмжээ дараах байдалтай байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2 Дунд түвшинээс гарч болзошгүй нөхөн төлбөрийн хэмжээ /төгрөг/

Хувилбар	Хураамжийн орлого	Гарах нөхөн төлбөрийн хэмжээ /А/
1	3 тэрбум	8,659,635,918.70
2	4 тэрбум	11,546,181,224.93
3	5 тэрбум	14,432,726,531.17

4.3. Дээд түвшний нөхөн төлбөрийн зардлын тооцоолол

Харин дээд түвшинд учирч болзошгүй эрсдэлийг өнгөрсөн 46 жилийн хорогдлын мэдээнд үндэслэн эрсдэлийн дээд түвшинд гарах нөхөн төлбөрийн хэмжээг даатгуулж болзошгүй хамгийн их малын үнэлгээгээр тооцоолж, нийт даатгалын үнэлгээнд эзлэх хувийг жил бүрийн хувьд гаргасан. Энэхүү нийт даатгалын үнэлгээнд эзлэх нөхөн төлбөрийн хувийн нягтын функцийн 1.0 хувийн итгэлцлийн түвшинд буюу VaR-ийн 0.99 түвшин нь 4.38 хувь байна. Өөрөөр хэлбэл нийт даатгалын үнэлгээнд эзлэх нөхөн төлбөрийн хувь нь 4.38 хувиас их байх магадлал 1.0 хувь байна. МИД-ын хураамжийн орлого болон даатгалын нийт үнэлгээний хэмжээнээс хамааран гарах нөхөн төлбөрийн хэмжээ дараах байдалтай байна (Хүснэгт 3).

